



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 05 сарын 12 өдөр

Дугаар А/135

Улаанбаатар хот

Нээлттэй сонгон шалгаруулалтын
баримт бичиг батлах тухай


Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4.5 дахь заалт, Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрмийн 3 дугаар зүйлийн 3.1.2, 3.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Харилцаа Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны “Тусгай зөвшөөрлийн тоо батлах тухай” 35 дугаар тогтоолын дагуу “Монгол улсын нутаг дэвсгэрт олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалтын баримт бичиг”-ийг нэгдүгээр, “Дорноговь аймгийн нутаг дэвсгэрт олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалтын баримт бичиг”-ийг хоёрдугаар, “Орон нутагт телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалтын баримт бичиг”-ийг гуравдугаар, “Орон нутагт арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалтын баримт бичиг”-ийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.
2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газар /З.Эрдэнэчулуун/-т даалгасугай.

ДАРГА

Г.ЧИНЗОРИГ

Харилцаа холбооны зохицуулах хорооны
даргын *2023* оны *05* сарын *12* өдрийн *Н/125*
тоот тушаалын дөрөвдүгээр хавсралт



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО

**ОРОН НУТАГТ АРИЛЖААНЫ РАДИОГИЙН
ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ-ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ
НЭЭЛТТЭЙ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН
БАРИМТ БИЧИГ**

ДУГААР : АРР-Орон нутаг 2023

Огноо: 2023 он

ОРШИЛ

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4.5 дахь заалт, , Радио долгионы тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх заалт, Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн энэхүү Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн жишиг баримт бичгийг баталсан.

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.1.6-д зааснаас бусад өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний төрөлд тусгай зөвшөөрлийг олгох Нээлттэй сонгон шалгаруулалтыг зохион байгуулах үнэлгээний ажлын хэсэг нь энэхүү жишиг баримт бичгийг удирдлага болгон Нээлттэй сонгон шалгаруулалтын баримт бичгийг боловсруулна. Нээлттэй сонгон шалгаруулалтын үнэлгээний ажлын хэсэг нь энэхүү жишиг баримт бичигт [.....] хаалтанд бичигдсэн хэсгийг бөглөхдөө тухайлсан Нээлттэй сонгон шалгаруулалтын баримт бичигт тусгагдсан тусгай болон нэмэлт мэдээллийг зайлшгүй нэмж тусгана.

Энэхүү жишиг баримт бичгийн тавдугаар бүлгийн өгөгдлийн хүснэгтэд заагдсан шаардлагууд нь өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага, хөтөлбөрийн болон хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалах радио, телевизийн хөтөлбөрийн дүрэм зэрэг бусад захиргааны хэм хэмжээний актад заагдсан шаардлагуудын хүрээнд өөрчлөгдөнө.

Нээлттэй сонгон шалгаруулалтын жишиг баримт бичигт өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулах ерөнхий шалгуур үзүүлэлтүүд, үнэлгээний ажлын хэсэг нь саналыг хэрхэн үнэлэх аргачлал, саналын маягт болон нээлттэй сонгон шалгаруулалтыг зохион байгуулах шаардлагатай бусад мэдээллийг багтаасан тул нээлттэй сонгон шалгаруулалтад оролцох эрх бүхий хуулийн этгээд нь өөрийн бэлтгэсэн нээлттэй сонгон шалгаруулалтын саналыг төлөвлөхдөө ашиглах бүрэн боломжтой.

Өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын газар

Харилцаа холбооны зохицуулах хороо

Утас: +976-11-304258, 1800-1858

Цахим хуудас: www.crc.gov.mn

Цахим хаяг: info@crc.gov.mn

ГАРЧИГ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НЭЭЛТТЭЙ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА, ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 1.1. Ерөнхий зүйл
- 1.2. Эрх бүхий этгээд
- 1.3. Албан ёсны хэл
- 1.4. Оролцогч тодруулга хүсэх
- 1.5. Оролцогч санал бэлтгэхээс өмнө танилцах
- 1.6. Оролцогчид тавигдах шаардлага
- 1.7. Сонгон шалгаруулалтын саналын иж бүрдэл
- 1.8. Саналын иж бүрдлийг хангах

ХОЁРДУГААР БҮЛЭГ. СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН САНАЛЫГ БЭЛДЭХ

- 2.1. Сонгон шалгаруулалтын саналыг бэлтгэх
- 2.2. Сонгон шалгаруулалтын саналд тэмдэглэгээ хийх
- 2.3. Саналын нэмэлт өөрчлөлт

ГУРАВДУГААР БҮЛЭГ. СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ҮНЭЛЭХ

- 3.1. Сонгон шалгаруулалтын үнэлгээний ажлын хэсэг
- 3.2. Сонгон шалгаруулалтын баримт бичигт өөрчлөлт оруулах
- 3.3. Сонгон шалгаруулалтын саналыг хүлээн авах
- 3.4. Сонгон шалгаруулалтын саналыг нээх
- 3.5. Сонгон шалгаруулалтын саналыг үнэлэх

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫГ БАТАЛГААЖУУЛЖ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ЭРХ ОЛГОХ

- 4.1. Гэрээ байгуулах эрх олгох
- 4.2. Сонгон шалгаруулалтын эрхийн төлбөр
- 4.3. Гэрээнд гарын үсэг зурах

ТАВДУГААР БҮЛЭГ. СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

- 5.1. Өгөгдлийн хүснэгт
- 5.2. Иж бүрдлийн хүснэгт
- 5.3. Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага
- 5.4. Гэрээний тусгай нөхцөл

МАЯГТУУД:

**ОРОН НУТАГТ АРИЛЖААНЫ РАДИОГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ НЭЭЛТТЭЙ СОНГОН
ШАЛГАРУУЛАЛТЫН УРИЛГА**

Зохион байгуулагч: **Харилцаа холбооны зохицуулах хороо**

Нээлттэй сонгон шалгаруулалтын дугаар: **APP-Орон нутаг 2023**

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4.5 дахь заалт, Радио долгионы тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх заалт, Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус үндэслэн Арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг дараах хамрах хүрээнд олгохоор нээлттэй сонгон шалгаруулалт зарлаж байна. Үүнд:

№	Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний төрөл	Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний хамрах хүрээ	Тусгай зөвшөөрлийн олгох хугацаа	Олгох тусгай зөвшөөрлийн тоо
1	Арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэх	Баянхонгор аймаг	5 жил	1
2		Булган аймаг		1
3		Дорноговь аймаг		1
4		Дундговь аймаг		1
5		Өвөрхангай аймаг		1
6		Сүхбаатар аймаг		1
7		Сэлэнгэ аймаг		1
8		Төв аймаг		1
9		Увс аймаг		1
10		Хэнтий аймаг		1

Нээлттэй сонгон шалгаруулалтад оролцох саналыг хүлээн авах эцсийн хугацаа:

[2023 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 10:00 цаг]

Нээлттэй сонгон шалгаруулалтад ирүүлсэн саналыг нээх хугацаа:

[2023 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 11:00 цаг]

Радиогийн үйлчилгээ эрхлэхэд Зөвшөөрлийн тухай хууль, Радио долгионы тухай хуульд заасны дагуу радио давтамж, давтамжийн зурвас ашиглах тул энэхүү сонгон шалгаруулалтад шалгарсан этгээдэд Радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл олгогдоно.

Нээлттэй сонгон шалгаруулалтад оролцохыг хүссэн этгээд нь **“Орон нутагт арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалтын баримт бичиг”**-ийг тус хорооны www.crc.gov.mn сайтаас татах болон хариуцсан мэргэжилтэнд хандан авах боломжтой.

Нээлттэй сонгон шалгаруулалтын саналыг доорх хаягаар ирүүлнэ.

Хаяг: Улаанбаатар хот 14201, Сүхбаатар дүүрэг,

Сүхбаатарын гудамж-13, Бага тойруу, 6 дугаар хороо,

Метро бизнес төв, А-корпус, 5 давхар,

Өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын газар

Хариуцсан мэргэжилтэн: Д.Уранбилэг

Утас: 304258

Цахим хуудас: www.crc.gov.mn

Цахим хаяг: uranbileg@crc.gov.mn

Огноо: [2023 оны 5 дугаар сарын 12-ны өдөр]

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НЭЭЛТТЭЙ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА, ТАВИГДАХ ШААРДЛАГА

1.1. Ерөнхий зүйл

1.1.1. Энэхүү нээлттэй сонгон шалгаруулалтыг Баянхонгор, Булган, Дорноговь, Дундговь, Өвөрхангай, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Увс, Хэнтий аймгуудын хамрах хүрээнд **арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэх, радио давтамж ашиглах** тусгай зөвшөөрөл олгох, гэрээ байгуулахаар зохион байгуулж байна.

1.1.2. Нээлттэй сонгон шалгаруулалтад (цаашид “Сонгон шалгаруулалт” гэх) Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, Харилцаа холбооны тухай хууль, Радио долгионы тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль болон бусад хууль тогтоомж болон энэхүү баримт бичгийг тус тус баримтална.

1.1.3. Арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэхэд Зөвшөөрлийн тухай хууль, Радио долгионы тухай хуульд заасны дагуу радио давтамж, давтамжийн зурвас ашиглах бөгөөд тус сонгон шалгаруулалтад шалгарсан этгээдэд Радио давтамж ашиглах тусгай зөвшөөрлийн гэрээг байгуулна. Радио давтамж ашиглах тусгай зөвшөөрлийн гэрээнд заасан давтамжийн үйлчлэх хүрээг нэмэгдүүлэх тохиолдолд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулна.

1.2. Эрх бүхий этгээд

1.2.1. Сонгон шалгаруулалтын урилга нь Монгол Улсад бүртгэлтэй, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 7.4.3, 7.4.6-д зааснаас бусад хуулийн этгээдэд нээлттэй.

1.2.2. Сонгон шалгаруулалтад Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, 7.4.3, 7.4.6-д заасан этгээдүүд болон дараах хуулийн этгээдийг эрх бүхий бус гэж үзнэ. Үүнд:

(а) Сүүлийн 3 жилийн хугацаанд тендер болон түүнтэй дүйцэхүйц үйл ажиллагаанд оролцох, гэрээ байгуулах болон гэрээ хэрэгжүүлэхдээ авлига, залилан мэхлэх үйл ажиллагаанд холбогдсон болох нь шүүх, эсхүл холбогдох байгууллагаар тогтоогдсон эсхүл шүүхээр шалгагдаж байгаа этгээдийг;

(б) Харилцаа холбооны чиглэлээр үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй этгээд нь сүүлийн 3 жилийн хугацаанд радио давтамжийн төлбөр, зохицуулалтын үйлчилгээний хөлстэй холбогдох асуудлаар төлбөр тооцооны өр төлбөртэй;

(в) Өмнө нь өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшиж байсан хуулийн этгээдийн тусгай зөвшөөрөл нь Зөвшөөрлийн тухай хууль, Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, Харилцаа холбооны тухай хууль, Радио долгионы тухай хууль болон холбогдох бусад хууль зөрчсөн үндэслэлээр хүчингүй болох эсхүл цуцлагдаж байсан бол уг хугацаанаас хойш 3 жил өнгөрөөгүй;

(г) Төлбөрийн чадваргүй болсон, татан буугдаж байгаа эсхүл татан буугдсан, дампуурлаас зайлсхийх зорилгоор зээлдүүлэгчтэй тохиролцсон, бизнесийн үйл ажиллагааг нь зогсоосон;

(д) Монгол Улсын хуулийн дагуу татвараа төлөөгүй, татвар, хураамжийн өртэй;

(е) Илт худал мэдээлэл бүхий санал ирүүлснийг эрх бүхий байгууллагаас тодруулсан эсхүл, ирүүлсэн санал болонтүүнд хавсарган ирүүлсэн мэдээлэл нь уг баримт бичигт тусгасан шалгуур

үзүүлэлт, шаардлагаас материаллаг зөрүүтэй болохыг үнэлгээний ажлын хэсэг тогтоосон.

1.3. Албан ёсны хэл

1.3.1. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх сонгон шалгаруулалттай холбоотой аливаа харилцааг зөвхөн Монгол хэлээр явуулах бөгөөд зөвхөн техникийн холбогдолтой зарим хавсралт материалууд англи хэл дээр байж болно. Бусад хэл дээрх материалыг Монгол хэл дээр орчуулан эх хувийг хавсаргасан байна.

1.4. Оролцогч тодруулга хүсэх

1.4.1. Сонгон шалгаруулалтад оролцогч (цаашид “Оролцогч” гэх) нь сонгон шалгаруулалттай холбоотой аливаа тодруулга авах хүсэлтийг үнэлгээний ажлын хэсэгт хаяглан гаргана.

1.4.2. Үнэлгээний ажлын хэсэг тодруулга өгөх ажлыг зохион байгуулах бөгөөд тодруулгыг хүсэлт гаргасан этгээдэд хүргүүлнэ.

1.4.3. Үнэлгээний ажлын хэсэг нь Сонгон шалгаруулалтын санал (цаашид “Санал” гэх)-ыг хүлээн авах эцсийн хугацаанаас 7 (долоо)-гоос доошгүй хоногийн өмнө албан бичгээр хүлээн авсан тодруулга, хүсэлтэд хариу өгнө.

1.5. Оролцогч санал бэлтгэхээс өмнө танилцах

1.5.1. Энэхүү баримт бичгийн 1.2.2-д заагдсан нөхцөл байдлаас үүдэн гарсан аливаа учирсан хохирлыг оролцогч өөрөө хариуцна.

1.5.2. Оролцогч этгээд нь санал бэлтгэхдээ Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжоор хүлээсэн тухайн үйлчилгээ эрхлэхтэй холбоотой үүрэг, тухайн үйлчилгээний зах зээл, онцлогийг харгалзан үзсэн байна. Оролцогч нь энэ талаарх мэдээллийг олж авахын тулд Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, хуульд заасан нөхцөл, шаардлага, дүрэм, журамтай сайтар танилцана.

1.5.3. Оролцогч сонгон шалгаруулалтын баримт бичиг, Монгол Улсын холбогдох хууль, захиргааны хэм хэмжээний актуудыг судалж, танилцсан гэдгээ баталгаажуулж, сонгон шалгаруулалтад оролцогчийн баталгааг гаргана.

1.6. Оролцогчид тавигдах шаардлага

1.6.1. Оролцогч нь тухайн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх чадвартай, дараах шалгуур үзүүлэлтийг хангасан байна. Үүнд:

- 1) Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, тухайн үйлчилгээнд хамаарах тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага;
- 2) Үйлчилгээ эрхлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх, бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлж, төлөвлөлтийн дагуу үйл ажиллагаа эхлүүлэхэд шаардлагатай санхүүгийн чадавхитай байх;
- 3) Сонгон шалгаруулалтын баримт бичигт заасан өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэхэд тавигдах мэргэжлийн боловсон хүчний шаардлагыг хангаж, тухайн чиглэлээр голлох мэргэжилтэй ажилтан болон инженер, техникийн ажилтнуудыг бүрдүүлсэн байх;
- 4) Тухайн үйлчилгээ эрхлэхэд шаардлагатай сүлжээ, студи, радио нэвтрүүлэгч төхөөрөмжийг тооцож төлөвлөсөн, ашиглах нэвтрүүлэгч, студийн тоног төхөөрөмж нь холбогдох стандарт, техникийн зохицуулалт болон аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан нийлүүлэгчийн мэдэгдэл;
- 5) Тухайн үйлчилгээний төрлөөс хамаарсан нэмэлт шалгуур үзүүлэлтүүд.

1.7. Сонгон шалгаруулалтын саналын иж бүрдэл

1.7.1. Оролцогч нь өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний тусай зөвшөөрлийн гэрээг хэрэгжүүлэх чадварыг тогтоохтой холбогдуулан энэхүү баримт бичгийн 1.7.2-т заасан мэдээллийг нотлох баримт болгон сонгон шалгаруулалтын саналд хамт ирүүлнэ.

1.7.2. Оролцогчийн саналын иж бүрдэл нь дараах хэсгээс бүрдэнэ. Үүнд:

- 1) Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтээ илэрхийлсэн өргөдөл;
- 2) Сонгон шалгаруулалтад оролцогчийн баталгаа;
- 3) Компанийн үйл ажиллагааны танилцуулга, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм;
- 4) Үйлчилгээ эрхлэх дунд хугацааны буюу 3-5 жилийн стратеги төлөвлөгөө (баталсан байх);
- 5) Үйлчилгээ эрхлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалт, хүний нөөц, шаардлагатай тоног төхөөрөмж, эдийн засгийн тооцоо судалгаа бүхий бизнес төлөвлөгөө (дэлгэрэнгүй);
- 6) Үйлчилгээ эрхлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалт, санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэх чадвартайгаа нотлох 2022 оны жилийн эцсийн баталгаажсан санхүүгийн дэлгэрэнгүй тайлан;
- 7) Стратеги болон бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц бүрдүүлсэн нотлох мэдээлэл;
- 8) Үйлчилгээ хүргэхэд шаардлагатай студийн болон нэвтрүүлэгч станцын үндсэн техник, тоног төхөөрөмжийн танилцуулга мөн студийн бүтэц, төхөөрөмжийн холболтын схем зураглал;
- 9) Ашиглахаар төлөвлөж буй тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлтүүд нь Олон Улсын болон Үндэсний стандартын шаардлагыг хангасан тухай нотолгоо, нийлүүлэгчийн мэдэгдэл;
- 10) Тухайн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний төрлөөс хамаарсан тусгай болон нэмэлт нөхцөл, шаардлагыг хангасан нотолгоонууд;
- 11) Оролцогчийн сонгон шалгаруулалтын эрхийн төлбөр төлсөн баримт, Харилцаа холбооны зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан тохиолдолд сонгон шалгаруулалтын эрхийн төлбөрийг буцаан авах хүсэлт;
- 12) Радио давтамж ашиглах хүсэлт,
- 13) Радио нэвтрүүлэгч станцын газар зүйн байршил, хамрах хүрээний зураглал, техникийн үзүүлэлт, ашиглах боломжтой радио давтамж, ажиллах технологи; Радио тоног төхөөрөмжийн ажиллагааны зарчим, холболтын схем зураглал;

1.8. Саналын иж бүрдлийг хангах

1.8.1. Оролцогчийн ирүүлэх санал нь тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээг эрхлэх чадвартай болохыг нотлон харуулахуйц байна.

1.8.2. Оролцогч нь саналын иж бүрдэлд дараах мэдээллийг тусгасан байна:

- 1) Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтээ илэрхийлсэн өргөдлийг **“Маягт-1”**-ийн дагуу гаргах;
- 2) Оролцогч сонгон шалгаруулалтын баримт бичигтэй сайтар танилцаж ойлгосон, Монгол Улсын хууль, захиргааны хэм хэмжээний актуудыг судалсан гэдгээ баталгаажуулж энэхүү баримт бичгийн **“Маягт-2”**-т зааснаар сонгон шалгаруулалтад оролцогчийн баталгааг гаргах;
- 3) Компанийн үйл ажиллагааны танилцуулгад компанийн байгуулагдсан хугацаа, гишүүдийн тоо, үйл ажиллагааны үндсэн чиглэл нь өргөн

- нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тухайн төрөлд тохирох, хэрэв ижил төстэй үйлчилгээ эрхэлж байсан бол энэ талаарх туршлага;
- 4) Оролцогч нь үйлчилгээ эрхлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалт, санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэх чадвартайгаа нотлох санхүүгийн тайлан, хэрэв хөрөнгө оруулалтыг өөр эх үүсвэрээс санхүүжүүлэх бол хөрөнгө оруулагчийн баталгаа, банкны тодорхойлолт, хөрөнгө оруулагчийн 2022 оны жилийн эцсийн баталгаажсан санхүүгийн тайлан;
 - 5) Энэхүү баримт бичгийн 1.7.2.(4),(5)-д заасан стратеги болон бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц бүрдүүлсэн тухай мэдээллийг ирүүлэхдээ “**Маягт-3**”-т зааснаар гаргах. Мэргэжилтэй ажилтныг бүрдүүлсэн байдлыг нотлохдоо мэргэжилтэй ажилтны мэргэжлийн боловсролын үнэмлэх, диплом, гэрчилгээний хуулбар, өөрийн ажилтны тухайд тухайн хуулийн этгээдийн ажилтан болохыг нотолсон баримт бичиг (НДШ төлсөн тодорхойлолт);
 - 6) Энэхүү баримт бичгийн 1.7.2.(8)-д заасан үндсэн техник, төхөөрөмжийн танилцуулга, жагсаалтыг “**Маягт-4**”-т зааснаар гаргаж, техникийн үндсэн үүрэг, зориулалт, үзүүлэлтүүдийг жагсаалтыг тоног төхөөрөмжийн холболтын схем, зураглал, тайлбарын хамт ирүүлэх;
 - 7) Энэхүү баримт бичгийн 1.7.2.(4)-д заасан дунд хугацааны стратеги төлөвлөгөөнд “**Маягт-5**”-ын дагуу саналыг хэрэгжүүлэх хугацааны хуваарийг заавал багтаана.
 - 8) Урилгад заасан өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний төрөл, онцлогоос хамаарч сонгон шалгаруулалтын баримт бичигт нэмэлт маягт оруулж болно.
 - 9) Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 26 дугаар тогтоолын хавсралтад зааснаар арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэх сонгон шалгаруулалтын эрхийн төлбөр **1,500,000 (Нэг сая таван зуун мянга)** төгрөг байх бөгөөд оролцогч тусгай зөвшөөрлийн эрхийн төлбөрийг тус хорооны Голомт банкны 1102626829 тоот дансанд байршуулж баримтын хамт ирүүлнэ.
 - 10) Радио нэвтрүүлэгчийн байгуулалтын зураглал, газар зүйн байршил, хамрах хүрээ, ашиглах радио давтамж, технологийн мэдээллийг “**Маягт-10**”-д заасны дагуу бөглөж ирүүлнэ.
 - 11) Тус хорооноос тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан тохиолдолд тусгай зөвшөөрлийн эрхийн төлбөрийг буцаан авах хүсэлтийг “**Маягт-6**”-д заасны дагуу ирүүлнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН САНАЛЫГ БЭЛТГЭХ

2.1. Сонгон шалгаруулалтын саналыг бэлтгэх

2.1.1. Саналын иж бүрдлийн хэсэг тус бүрийн 1 (нэг) эх хувь байна. [\[шаардлагатай хуулбар хувийн тоо\]](#) хуулбар хувь, 1 (нэг) цахим хувь байна.

2.1.2. Саналын иж бүрдлийн цахим хувийг Microsoft Excel, Adobe PDF хэлбэрүүдээр бэлтгэсэн байна. Саналын материалыг зөвхөн цахимаар ирүүлэх бол тавигдах шаардлагыг өгөгдлийн хүснэгтэд тусгасан байна.

2.1.3. Оролцогч энэхүү баримт бичгийн 5.2 (иж бүрдлийн хүснэгт)-д заасан сонгон шалгаруулалтын саналын иж бүрдэл болон бусад бичиг баримтын эх хувийг бэлтгэн хавтаслаж, түүнд “ЭХ ХУВЬ” гэсэн тодорхой бичиглэл хийнэ.

2.1.4. Оролцогч үүнээс гадна шаардлагатай бол [хуулбар хувийн тоо] ширхэг сонгон шалгаруулалтын саналын хуулбар хувийг бэлтгэн хавтаслаж, түүнд

“ХУУЛБАР ХУВЬ” гэсэн тодорхой бичиглэл хийнэ. Эх хувь болон хуулбар хувь хоорондоо зөрчилдсөн тохиолдолд эх хувийг баримтална.

2.2. Сонгон шалгаруулалтын саналд тэмдэглэгээ хийх

2.2.1. Энэхүү баримт бичгийн 2.1-д заасан дугтуй, цахим хувийг нэгтгэн битүүмжлэн (гадна битүүмжлэл) дугтуйн зүүн дээд буланд доорхи тэмдэглэгээг хийнэ:

А. Сонгон шалгаруулалтын баримт бичгийн дугаар;

Б. Сонгон шалгаруулалтын нэр, төрөл, хамрах хүрээ;

В. Сонгон шалгаруулалтын санал хүлээн авах эцсийн хугацаа;

Г. Сонгон шалгаруулалтын санал ирүүлэх хаяг;

Д. Оролцогчийн нэр, хаяг;

Е. [Сонгон шалгаруулалтын саналыг нээх огноо] өдрийн [цаг]-аас өмнө “НЭЭЖ ҮЛ БОЛНО” гэсэн бичиглэл;

2.2.2. Сонгон шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлагын дагуу битүүмжилж, тэмдэглэгээ хийгээгүйгээс санал буруу хаягаар хүргэгдсэн эсхүл саналыг нээхээс өмнө битүүмжлэл задарвал үнэлгээний ажлын хэсэг хариуцлага хүлээхгүй бөгөөд саналаас шаардлага хангаагүй гэсэн үндэслэлээр татгалзана.

2.2.3. Саналын эх хувийг компьютер дээр бэлтгэж, оролцогчийг төлөөлөх эрх бүхий этгээд боловсруулсан эх материалын хуудас бүрийг дугаарлан тамга дарж баталгаажуулна.

2.3. Саналын нэмэлт, өөрчлөлт

2.3.1. Оролцогч нь санал хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө өөрийн хүргүүлсэн саналдаа нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Хэрэв саналд нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд санал хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө энэ тухайгаа албан бичгээр хүсэлт гарган, нэмэлт, өөрчлөлт оруулсан саналын хамт сонгон шалгаруулалтын үнэлгээний ажлын хэсэгт хандан ирүүлнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ҮНЭЛЭХ

3.1. Сонгон шалгаруулалтын үнэлгээний ажлын хэсэг

3.1.1. Үнэлгээний ажлын хэсэг нь дараах 5-аас доошгүй гишүүний бүрэлдэхүүнтэй байна:

а). Дарга;

б). Нарийн бичгийн дарга;

в). Гишүүд.

3.1.2. Үнэлгээний ажлын хэсгийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд бүх гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь оролцсоноор хуралдаан хүчин төгөлдөр болно.

3.1.3. Үнэлгээний ажлын хэсгийн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох талаарх дүгнэлт гаргана. Дүгнэлтийг үнэлгээний ажлын хэсгийн дарга Зохицуулах хорооны хуралд танилцуулж, шийдвэрлүүлнэ.

3.1.4. Үнэлгээний ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэл, дүгнэлтэд даргалагч, нарийн бичгийн дарга, болон гишүүд гарын үсэг зурснаар баталгаажна. Тэмдэглэлд тухайн хуралдаанаар хэлэлцсэн асуудлын танилцуулга болон холбогдох баримт бичгийг хавсаргана.

3.1.5. Үнэлгээний ажлын хэсгийн бүрэлдэхүүн энэхүү баримт бичгийн "МАЯГТ-7"-д заасан нууцын баталгааг гаргана.

3.1.6. Үнэлгээний ажлын хэсгийн бүрэлдэхүүн нь сонгон шалгаруулалтын саналыг үнэлэх, харьцуулах болон гэрээ байгуулах эрх олгох талаарх дүгнэлттэй холбогдон үүсэх харилцаанаас олж авсан бүхий л мэдээллийг задруулахыг хориглоно.

3.2. Сонгон шалгаруулалтын баримт бичигт өөрчлөлт оруулах

3.2.1. Харилцаа холбооны зохицуулах хороо (цаашид "Зохицуулах хороо" гэх) нь саналыг хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас 5 хоногийн өмнө сонгон шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

3.2.2. Сонгон шалгаруулалтын баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлт нь сонгон шалгаруулалтын баримт бичгийн салшгүй хэсэг болох бөгөөд түүнийг сонгон шалгаруулалтын баримт бичиг худалдан авсан бүх оролцогчдод бичгээр мэдэгдэнэ.

3.2.3. Шаардлагатай бол сонгон шалгаруулалтын жишиг баримт бичигт орсон нэмэлт, өөрчлөлтийг тусгах хангалттай хугацааг оролцогчдод олгох үүднээс Зохицуулах хороо нь энэхүү баримт бичгийн 3.4.3-т заасны дагуу сонгон шалгаруулалтын саналыг хүлээн авах эцсийн хугацааг нэг (1) удаа сунгаж болно.

3.3. Сонгон шалгаруулалтын саналыг хүлээн авах

3.3.1. Үнэлгээний ажлын хэсэг нь саналыг энэхүү баримт бичгийн 2.1, 2.2-т заасны дагуу сонгон шалгаруулалтад ирүүлсэн саналын материалын зөвхөн гаднах хайрцгийн битүүмжлэл, бичиглэлийг шалгаж, хүлээн авна.

3.3.2. Үнэлгээний ажлын хэсэг нь оролцогчийн ирүүлсэн санал нь энэхүү баримт бичгийн 2.1, 2.2-д заасан шаардлагуудыг хангаагүй тохиолдолд ирүүлсэн сонгон шалгаруулалтын саналыг хүлээж авахаас татгалзаж, тэмдэглэл үйлдэнэ.

3.3.3. Үнэлгээний ажлын хэсэг нь [2023 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 10:00 цаг] цагаас өмнө ирүүлсэн саналын гадна битүүмжлэл, тэмдэглэгээг шалган энэхүү сонгон шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлагыг хангасан бол бүртгэж, хүлээн авах бөгөөд шаардлага хангаагүй бол хүлээн авахаас татгалзаж, тэмдэглэл үйлдэнэ.

3.3.4. Үнэлгээний ажлын хэсэг нь [Харилцаа холбооны зохицуулах хороо, Метро бизнес төв А-блок 12 давхар, Д.Сүхбаатарын гудамж-13, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар 14201-0033 хаягт 2023 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 11:00 цаг] цагт оролцогчдын талаар ерөнхий мэдээлэл хийнэ. Ерөнхий мэдээлэл хийх үед оролцогчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч байлцаж болно. Ерөнхий мэдээлэл хийх үед хийсэн тэмдэглэлд үнэлгээний ажлын хэсгийн бүрэлдэхүүн болон байлцсан оролцогчид гарын үсэг зурна.

3.3.5. Сонгон шалгаруулалтын төслийг хүлээн авахад <http://www.worldtimeserver.com> цагийг баримтална.

3.4. Сонгон шалгаруулалтын саналыг нээх

3.4.1. Үнэлгээний ажлын хэсэг нь хүлээн авсан саналыг оролцогчдын төлөөллийг байлцуулан Сонгон шалгаруулалт хүлээн авах эцсийн хугацаанаас хойш 1 (нэг) цагийн дотор нээнэ.

3.4.2. Ирүүлсэн саналын материалыг нээх үед оролцогчийн төлөөлөгч байлцах эрхтэй ба байлцсан бол Сонгон шалгаруулалтыг нээсэн тэмдэглэлд гарын үсгээ зурна. Оролцогчдод албан ёсоор мэдэгдсэний дараа саналыг нээх ажиллагаанд оролцоогүй, гарын үсэг зураагүйгээс үүсэх хариуцлагыг Зохицуулах хороо хүлээхгүй.

3.4.3. Үнэлгээний ажлын хэсэг баримт бичгийн 3.2.3-т заасны дагуу Сонгон шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулсны улмаас санал хүлээн авах эцсийн хугацааг сунгасан тохиолдолд үнэлгээний ажлын хэсэг болон оролцогчийн эрх, үүрэг сунгасан хугацааны туршид хэвээр үйлчилнэ.

3.5. Сонгон шалгаруулалтын саналыг үнэлэх

3.5.1. Үнэлгээний ажлын хэсэг саналыг нарийвчлан үнэлэхээс өмнө ирүүлсэн саналын иж бүрдлийн бүх болзлыг хангасан эсэхийг энэхүү баримт бичгийн 5.2-т заасан иж бүрдлийн хүснэгтийн дагуу хянан үзнэ.

3.5.2. Шаардлагад нийцсэн санал гэдэг нь сонгон шалгаруулалтын баримт бичгийн иж бүрдлийн бүх болзлыг хангасан саналыг хэлнэ.

3.5.3. Зохицуулах хороо шаардлагад үл нийцсэн гэж тогтоогдсон саналыг цаашид үнэлэхээс татгалзана.

3.5.4. Зохицуулах хороо зөвхөн шаардлагад нийцсэн гэж тогтоогдсон саналыг дараах байдлаар оноогоор харьцуулан үнэлнэ.

Нөхцөл шаардлагууд	Үнэлгээний оноо
Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэхээр төлөвлөсөн хэрэгжүүлэх төслийн шийдэл <i>(тухайн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний төрөл, онцлогоос хамаарсан нөхцөл, шаардлага хангасан эсэх гол үзүүлэлтүүдийг тусган авч үзэх)</i>	35 хүртэл
Үйл ажиллагаа эрхлэх санхүүгийн чадавхи	15 хүртэл
Техникийн нөхцөл шаардлага хангасан байдал <ul style="list-style-type: none">• <i>Студид шаардлагатай тоног төхөөрөмжийг төлөвлөсөн байдал (MNS 5591-2:2016)</i>• <i>Радио нэвтрүүлэгч станцын шаардлага хангасан байдал (MNS 4909:2000)</i>	<ul style="list-style-type: none">• 15 хүртэл• 15 хүртэл
Туршлага, мэргэжлийн ажилтнуудаар хангагдсан байдал	15 хүртэл
Үйл ажиллагааг хэрэгжүүлэх хуваарь	5 хүртэл
Үйлчилгээний үнэ тариф	-

3.5.5. Зохицуулах хороо нь оролцогчийн ирүүлсэн саналыг 100 хүртэл оноогоор үнэлж, авсан оноогоор харьцуулалт хийж байр эзлүүлнэ.

3.5.6. Авбал зохих 100 онооны 70 ба түүнээс дээш оноо авсан эхний [тухайн аймагт тогтоосон тусгай зөвшөөрлийн квотын тооны] оролцогчийн саналыг шалгарсанд тооцно.

3.5.7. Авбал зохих 100 онооны 70 ба түүнээс дээш оноог аваагүй тохиолдолд тухайн оролцогчийн ирүүлсэн саналыг шалгараагүйд тооцно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫГ БАТАЛГААЖУУЛЖ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ЭРХ ОЛГОХ

4.1. Гэрээ байгуулах эрх олгох

4.1.1. Үнэлгээний ажлын хэсэг нь энэхүү баримт бичгийн 3.5.6-д заасны дагуу авбал зохих онооны 70-аас дээш оноог авсан эхний (квотод заасан тооны) оролцогчид гэрээ байгуулах эрх олгох талаарх дүгнэлтийг Зохицуулах хорооны хурлаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлнэ.

4.1.2. Үнэлгээний ажлын хэсэг нь Зохицуулах хорооны тусгай зөвшөөрөл олгох тухай тогтоол батлагдсаны дараа Сонгон шалгаруулалтад шалгарсан оролцогчид гэрээ байгуулах эрх олгосон тухай, бусад оролцогчдод шалгараагүй тухай мэдэгдлийг тус тус албан бичгээр мэдэгдэнэ.

4.2. Сонгон шалгаруулалтын эрхийн төлбөр

4.2.1. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 26 дугаар тогтоолын хавсралтад зааснаар “Орон нутагт арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл” олгох сонгон шалгаруулалтын эрхийн төлбөр **1,500,000 (Нэг сая таван зуун мянга)** төгрөг байна. Оролцогч нь сонгон шалгаруулалтад оролцохдоо эрхийн төлбөрийг **Голомт банкны 1102626829** тоот дансанд байршуулж, баримтыг саналын хамт ирүүлнэ.

4.2.1(1) Тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан оролцогчид сонгон шалгаруулалтын эрхийн төлбөрийг буцаан олгоно.

4.2.2. Эрхийн төлбөрийг эхний жилд нэг удаа төлнө. Эрхийн төлбөрт эхний жилийн зохицуулалтын үйлчилгээний хөлс багтана. Хэрэв сонгон шалгаруулалтаар радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл олгогдсон бол радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийг эхний жилээс эхлэн төлнө.

4.2.3. Сонгон шалгаруулалтад шалгарсан оролцогч нь тусгай зөвшөөрлийн ээлжит жилийн төлбөрийг Зохицуулах хорооноос баталсан “Тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд үзүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ”-нд заасан зохицуулалтын үйлчилгээний хөлсийг болон “Радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөр”-ийг жил бүр төлнө. /Жич: Энэхүү төлбөр нь баримт бичгийн 4.2.1-д заасан эрхийн төлбөрөөс тусдаа төлбөр болно/

4.3. Гэрээнд гарын үсэг зурах

4.3.1. Сонгон шалгаруулалтад шалгарсан оролцогч нь гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл хүргүүлснээс хойш ажлын 10 өдрийн дотор [тусгай зөвшөөрлийн төрөл, хамрах хүрээ] эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрээнд гарын үсэг зурж, тамга тэмдэгээр баталгаажуулан гэрээг эцэслэн байгуулна.

ТАВДУГААР БҮЛЭГ
СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

5.1. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

Өгөгдлийн хүснэгтийн холбогдох заалт	Ерөнхий зүйл
	Сонгон шалгаруулалт зохион байгуулагч: Харилцаа холбооны зохицуулах хороо (Метро бизнес төв А-блок 5 давхар Д.Сүхбаатарын гудамж-13 Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар 14201-0033 Утас: 304258, Факс: 327720)
	Харилцаа холбооны зохицуулах хороог төлөөлж Э.Золбаяр Өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын газрын дарга Утас:304258 Д.Уранбилэг Радиоогийн зохицуулалтын хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн Зохицуулалтын хэрэгжилтийн хэлтэс Өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын газар Харилцаа холбооны зохицуулах хороо uranbileg@crc.gov.mn Утас:304258
1.2	Сонгон шалгаруулалтад Монгол Улсад бүртгэлтэй, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 7.4.3, 7.4.6-д зааснаас бусад хуулийн этгээд оролцох эрхтэй. Оролцогч нь Сонгон шалгаруулалтын баримт бичгийн (СШББ)1.2.2-т заасны дагуу эрх бүхий эсэхийг тус хорооны мэдээллийн санд байх мэдээлэл болон оролцогчоос ирүүлэх дараах баримт, нотолгоо зэрэгт үндэслэн сонгон шалгаруулалтын ажлын хэсэг тогтооно. <ul style="list-style-type: none"> • Тухайн аж ахуйн нэгж нь Монгол улсын хууль тогтоомж зөрчиж аливаа шүүхийн маргаантай асуудалд холбогдсон эсэх талаарх холбогдох байгууллагын тодорхойлолт ирүүлэх (Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага); • Оролцогч хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрмийн хуулбарыг ирүүлэх; • Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамжаа төлсөн баримт ирүүлэх; (Харъяа татварын байгууллагын тодорхойлолт) • Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 7.3.5-д заасныг үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөл, удирдлагын багийн бүрэлдэхүүний танилцуулга МАЯГТ-8-ын дагуу (аль улсын иргэн болохыг бичиж, гадаадын иргэн бол паспортын хуулбар, гадаадын хуулийн этгээд бол тухайн хуулийн этгээдийн гэрчилгээний хуулбар, түүний албан ёсны орчуулгын баталгаажуулсан хувийг ирүүлнэ); • Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 7.4.3, 7.4.6, 18.1-ийг үндэслэн уг хуулийн 9.2-т заасан мэдээллийг МАЯГТ-9-ийн дагуу гаргаж ирүүлэх;
1.3.	Саналыг Монгол хэлээр ирүүлнэ. Тийм
1.4.	Санал хүлээн авах эцсийн хугацаанаас 7 (долоо)-гоос доошгүй хоногийн өмнө албан бичгээр (албан бичгийн хуулбарыг урьдчилан uranbileg@crc.gov.mn и-мэйл хаягаар ирүүлж болно) хүлээн авсан тодруулга, хүсэлтэд баримт бичгийн 1.4.2-т зааснаар хариу өгнө. Тодруулга хүлээн авах хаяг: Харилцаа холбооны зохицуулах хороо Улаанбаатар хот 14201, Сүхбаатар дүүрэг, Сүхбаатарын гудамж-13, Бага тойруу, 6 дугаар хороо Метро бизнес төв, А-корпус, 5 давхар,

	Өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын газар Хариуцсан мэргэжилтэн: Д.Уранбилэг Утас: 304258
1.5	Оролцогч нь санал бэлтгэхдээ Зөвшөөрлийн тухай хууль, Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, Харилцаа холбооны тухай хууль, Радио долгионы тухай хууль, Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийн журам, Радиогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага, Радиогийн хөтөлбөрт тавигдах шаардлага, Радиогоор нэвтрүүлэх зар сурталчилгааны зохицуулалтын журам зэрэг холбогдох хууль тогтоомжуудыг сайтар судалж, танилцсан тухай баталгаа гаргаж ирүүлнэ. (Маягт-2 -ын дагуу)
1.6.1 (1)	Сонгон шалгаруулалтад оролцогчид тавих шаардлага Энэхүү сонгон шалгаруулалтад оролцогчид тавигдах шаардлага нь тухайн орон нутагт арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэгчдийг сонгон шалгаруулах үзүүлэлт болох бөгөөд Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, тухайн үйлчилгээнд хамаарах тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагад нийцсэн эсэхийг авч үзнэ. 1. Тус хорооны 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 88 дугаар тогтоолоор баталсан “Радиогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага”-ын 3-р зүйлд заасан үйлчилгээ эрхлэх 3-5 жилийн стратеги төлөвлөгөөг гаргаж ирүүлэх; <ul style="list-style-type: none"> - Хөтөлбөрийн бодлого, төлөвлөлт нь Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, Радиогийн хөтөлбөрт тавигдах шаардлага, Радиогоор нэвтрүүлэх зар сурталчилгааны зохицуулалтын журмын холбогдох заалтуудад нийцсэн байх; Тухайлбал Монгол бүтээлийн эзлэх хувь, өөрийн бүтээл үйлдвэрлэл, тухайн орон нутгийн иргэдэд чиглэсэн, тухайн орон нутагт бүтээсэн мэдээ, мэдээлэл, нэвтрүүлгийн хувь хэмжээ нь Радиогийн хөтөлбөрт тавигдах шаардлагад нийцсэн байна. - Тухайн орон нутагтаа арилжааны радиогийн үйлчилгээний хүрээнд бэлтгэн нэвтрүүлэх хөтөлбөрийн бодлого, төлөвлөлт, бэлтгэн нэвтрүүлэхээр төлөвлөсөн нэвтрүүлгүүдийн талаар стратеги төлөвлөгөөний хүрээнд гаргаж, тодорхой тусгасан байх; - Бэлтгэн, нэвтрүүлэхээр төлөвлөсөн нэвтрүүлгийн жагсаалт, товч танилцуулгуудын хамт гаргах; (Үүнд: тухайн орон нутгийн иргэдэд чиглэсэн мэдээ, мэдээлэл, нэвтрүүлгийг тусгасан байх) - Өөр бусад студи, продакшнаас нэвтрүүлэг, бүтээл авч хөтөлбөртөө тусгахаар төлөвлөсөн бол энэ талаарх мэдээлэл, нэвтрүүлэхээр төлөвлөж байгаа бүтээл, нэвтрүүлгийн жагсаалт 2. Бизнес төлөвлөгөө гаргаж ирүүлэх; <ul style="list-style-type: none"> - Үйлчилгээ эрхлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалт, хүний нөөц, шаардлагатай тоног төхөөрөмж, үйлчилгээний үнэ тариф, эдийн засгийн тооцоо судалгаа бүхий бизнес төлөвлөгөө - Дунд хугацааны стратеги төлөвлөгөөнд саналыг хэрэгжүүлэх хугацааны хуваарийг СШББ-ын 1.8.2.(7)-д зааснаар “Маягт 5”-ын дагуу заавал багтаасан байх
1.6.1(2)	Үйлчилгээ эрхлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх, бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлж, төлөвлөлтийн дагуу үйл ажиллагаа эхлүүлэхэд шаардлагатай санхүүгийн чадавхийг нотлох баримт: Шаардлагатай хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байх; <ul style="list-style-type: none"> - Санхүүгийн чадавхийг тодорхойлох зорилгоор 2022 оны жилийн эцсийн баталгаажсан санхүүгийн тайлан, харилцагч банкны тодорхойлолт; - Шинээр үүсгэн байгуулагдсан хуулийн этгээдийн хувьд эхлэлийн хөрөнгийн баланс, харилцагч банкны тодорхойлолт; - Шаардлагатай бол санхүүжилт хийх хөрөнгө оруулагч этгээдийн 2022 оны жилийн эцсийн баталгаажсан санхүүгийн тайлан, эсхүл санхүүгийн эх үүсвэрийн нотлох баримтыг хөрөнгө оруулалт хийх тухай тодорхойлолтын хамт ирүүлэх; - Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж байгаа бол бүртгэгдсэн хөрөнгийн жагсаалт.
	Саналд тусгасан санхүүгийн бүх тооцооллыг төгрөгөөр илэрхийлнэ.

	Техник төхөөрөмжтэй холбоотой тооцоолол, төсөвт үнийн дүнг валютаар илэрхийлж болох ч төгрөгөөр давхар илэрхийлсэн байна.
1.6.1(3)	Оролцогчийн тухайн үйлчилгээ эрхлэхээр төлөвлөсөн мэргэжлийн боловсон хүчинд тавигдах шаардлага: Стратеги, бизнес төлөвлөгөө болон Радиогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэргэжлийн инженер техникийн болон сэтгүүлзүйн ажилтнуудаар хүний нөөцийг бүрдүүлсэн байх; “ Маягт-3 ”-ыг бөглөж, ажилтнуудын туршлагыг харуулсан товч тодорхойлолт, мэргэжлийн үнэмлэх, дипломны хуулбарыг хавсарган ирүүлэх;
1.6.1 (4)	Тухайн үйлчилгээ эрхлэхэд шаардлагатай техникийн шаардлага: Радиогийн үйлчилгээ эрхлэхэд шаардлагатай студи, үндсэн техник, тоног төхөөрөмжийг тооцож төлөвлөсөн, ашиглах техник, тоног төхөөрөмж нь холбогдох стандарт, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан байх. <ul style="list-style-type: none"> • Студид ашиглах үндсэн тоног төхөөрөмжийн талаар “Маягт-4”-ийг бөглөж, студийн төлөвлөлт-зураг, тоног төхөөрөмжийн холболтын схем, зураглал, тайлбарыг хавсаргаж ирүүлэх ; • Радио нэвтрүүлэгч станц, антен фидерийн байгууламжийн төлөвлөлт, ашиглах тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлт, нэвтрүүлэх станцын зураглал, газар зүйн байршил, хамрах хүрээ, ашиглах радио давтамж, технологийн мэдээллийг “Маягт-10”-д заасны дагуу хавсаргаж ирүүлнэ.
1.6.1 (5)	Тухайн үйлчилгээний төрлөөс хамаарсан нэмэлт шаардлага, тэдгээрийг нотлох баримт, нотолгоонууд ирүүлэх: Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхлэх арилжааны радиогийн үйлчилгээний хувьд дараах онцлог, хөтөлбөрт тавигдах нэмэлт шаардлага нь СШББ-ийн 1.6.1 (1) -д заасан сонгон шалгаруулах үзүүлэлтэд хамаарах бөгөөд ирүүлсэн хөтөлбөр төлөвлөлт, нэвтрүүлэхээр төлөвлөсөн бүтээлийн жагсаалтад үндэслэн шаардлага хангасан эсэхийг үнэлгээнд харгалзан үзнэ. <ul style="list-style-type: none"> • Тухайн орон нутгийн иргэдэд чиглэсэн мэдээ, мэдээлэл, нэвтрүүлэг бэлтгэн хүргэхээр төлөвлөж, хөтөлбөртөө тусгасан, энэ нь 7 хоногийн хөтөлбөрийн нийт цагийн 30 хувиас доошгүй байх; • Жилд нэвтрүүлэхээр төлөвлөсөн дараах бүтээл нэвтрүүлгийн хувь хэмжээ нь Радиогийн хөтөлбөрт тавигдах шаардлага хангахуйц байхаар тус тус төлөвлөнө. Үүнд: Жилд- <ul style="list-style-type: none"> ○ Үндэсний түүх, соёл, уламжлал, хүүхэд, танин мэдэхүйн нэвтрүүлэг- 360 цагаас багагүй
	Санал ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулагдах эсэх: Үгүй
	Сонгон шалгаруулалтад заасан үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа: Тусгай зөвшөөрөл олгосноос хойш 5 жил байна.
1.7.2.(1)	Сонгон шалгаруулалтад хүсэлтээ илэрхийлсэн өргөдөл;
1.7.2.(3)	Компанийн үйл ажиллагааны дэлгэрэнгүй танилцуулга;
1.8.2(9)	Оролцогч СШББ-ын 4.2.1-т заасны дагуу сонгон шалгаруулалтын эрхийн төлбөр болох 1,500,000 (Нэг сая таван зуун мянган) төгрөгийг тус хорооны Голомт банкны 1102626829 тоот дансанд байршуулж, баримтыг саналын хамт ирүүлнэ . Тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан тохиолдолд тусгай зөвшөөрлийн эрхийн төлбөрийг буцаан олгох бөгөөд оролцогч нь тусгай зөвшөөрлийн эрхийг төлбөрийг буцаан авах хүсэлтийг Маягт-6 -д заасны дагуу ирүүлнэ.
4.2.1	
4.2.2	Сонгон шалгаруулалтын эрхийн төлбөрт шалгарсан оролцогчийн тусгай зөвшөөрөл авсан эхний жилийн зохицуулалтын үйлчилгээний хөлс багтсан болно. Харин радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийг эхний жилээс эхлэн төлнө.

2.1.1	<p>Санал ирүүлэх хэлбэр нь: Тухайн үйлчилгээ хүргэхээр төлөвлөсөн БҮРЭН ХЭМЖЭЭНИЙ САНАЛ байна. Саналын зөвхөн ЭХ ХУВИЙГ ирүүлнэ. ХУУЛБАР ХУВЬ - Шаардлагагүй ЦАХИМ ХУВЬ – Шаардлагагүй</p> <p>2.1.1. Саналын иж бүрдлийн хэсэг тус бүрийн 1 (нэг) эх хувь, 2.1.2. Оролцогч энэхүү баримт бичгийн 5.2 (иж бүрдлийн хүснэгт)-д заасан сонгон шалгаруулалтын саналын иж бүрдэл болон бусад бичиг баримтын эх хувийг бэлтгэн хавтаслаж, түүнд “ЭХ ХУВЬ” гэсэн тодорхой бичиглэл хийнэ.</p>
2.2.1.	<p>Дугтуйлах, битүүмжлэх, тэмдэглэгээ хийх:</p> <p>Саналын ЭХ ХУВИЙГ дугтуйнд битүүмжлэн, СШББ-ийн 2.2-т заасны дагуу тэмдэглэгээг бүрэн гүйцэт хийж заасан хаягаар, тогтоосон хугацаанд баггаан ирүүлнэ.</p> <p>2.2.1. Энэхүү баримт бичгийн 2.1-д зааснаар битүүмжлэн (гадна битүүмжлэл) дугтуйн зүүн дээд буланд доорхи тэмдэглэгээг хийнэ: А. Сонгон шалгаруулалтын баримт бичгийн дугаар; Б. Сонгон шалгаруулалтын нэр, төрөл, хамрах хүрээ; В. Сонгон шалгаруулалтын санал хүлээн авах эцсийн хугацаа; Г. Сонгон шалгаруулалтын санал ирүүлэх хаяг; Д. Оролцогчийн нэр, хаяг; Е. [2023 оны 06 дугаар сарын 12-ны] өдрийн [11:00] цагаас өмнө “НЭЭЖ ҮЛ БОЛНО” гэсэн бичиглэл;</p>
2.2.3	<p>Саналын эх хувийг компьютер дээр бэлтгэж, оролцогчийг төлөөлөх эрх бүхий этгээд боловсруулсан материалын хуудас бүрийг дугаарлан тамга дарж баталгаажуулна.</p>
3.3.	<p>Саналыг хүлээн авах: Үнэлгээний ажлын хэсэг саналыг хүлээн авахдаа СШББ-ийн 3.3-т заасны дагуу шалгаж авах бөгөөд 2.1, 2.2-д заасан шаардлагуудыг хангаагүй тохиолдолд ирүүлсэн сонгон шалгаруулалтын саналыг хүлээж авахаас татгалзаж тэмдэглэл үйлдэнэ.</p>
3.3.3	<p>Саналыг ирүүлэх эцсийн хугацаа: (2023 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 10:00 цагаас өмнө) Санал ирүүлэх хаяг: (Харилцаа холбооны зохицуулах хороо Метро бизнес төв А-блок 5 давхар Д. Сүхбаатарын гудамж-13 Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар 14201-0033 Утас: 304258, Факс: 327720)</p>
3.4	<p>Санал нээх: Харилцаа холбооны зохицуулах хороо Метро бизнес төв А-блок 5 давхар, Д. Сүхбаатарын гудамж-13, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар 14201-0033 хаяг Саналын нээлт хийх огноо, цаг нь: 2023 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 11:00 цаг</p>
3.5.4	<p>Сонгон шалгаруулалтын үнэлгээний шалгуур үзүүлэлт, оноо: Нийт оноо: 100 Авбал зохих доод оноо: 70</p>
4.1	<p>Шалгарсан оролцогчтой арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрээ байгуулах хугацаа: тусгай зөвшөөрөл олгох шийдвэр гарснаас хойш ажлын 10 хоног Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 10.9-д заасны дагуу шалгарсан этгээд эрх бүхий этгээдээс шалгарсан тухай мэдэгдэл хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор гэрээг байгуулаагүй тохиолдолд дараагийн өндөр оноо авсан оролцогчтой гэрээг байгуулна.</p>
4.2.1	<p>Тусгай зөвшөөрлийн эрхийн төлбөр төлөх баталгаа шаардана. Тусгай зөвшөөрлийн эрхийн төлбөрийн үнийн дүн: 1,500,000 төгрөг</p>
4.3	<p>Сонгон шалгаруулалтын баримт бичигт заасан үйлчилгээг талууд гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс хойш эхлүүлэх хугацаа: Харилцаа холбооны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т зааснаар 1 жилийн дотор үйл ажиллагааг эхлүүлэх</p>

5.2. ИЖ БҮРДЛИЙН ХҮСНЭГТ

(Энэхүү сонгон шалгаруулалтын баримт бичгийн 1.7, 1.8-д заасан иж бүрдлийн шаардлагын дагуу гаргах)

Сонгон шалгаруулалтад оролцогч тухайн материалыг бүрдүүлсэн бол ✓ тэмдэглэгээ хийж, хуудасны дугаарыг тэмдэглэнэ	Энэхүү баримт бичгийн холбогдох заалт	Сонгон шалгаруулалтын төслийн материалын иж бүрдэл
	1.2.2 (а)	Тухайн аж ахуйн нэгж нь Монгол улсын хууль тогтоомж зөрчиж аливаа шүүхийн маргаантай асуудалд холбогдсон эсэх талаарх холбогдох байгууллагын тодорхойлолт ирүүлэх (шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага гэх мэт);
	1.2.2.(г)	Оролцогч хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрмийн хуулбар ирүүлэх;
	1.2.2 (д)	Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөр төлсөн баримт ирүүлэх; (Харъяа татварын байгууллагын тодорхойлолт)
	1.2.2	Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 7.3.5-д заасныг үндэслэн төлөөлөн удирдах зөвлөл, удирдлагын багийн бүрэлдэхүүний танилцуулга. МАЯГТ-8-ын дагуу;
	1.2.2	Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 7.4.3, 7.4.6-г үндэслэн уг хуулийн 9.2-т заасан мэдээллийг МАЯГТ-9-ийн дагуу гаргаж ирүүлэх;
	1.7.2.(1)	Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтээ илэрхийлсэн өргөдөл;
	1.7.2.(2)	Сонгон шалгаруулалтад оролцогчийн баталгаа; МАЯГТ-2-ын дагуу бөглөж ирүүлэх;
	1.7.2.(3)	Компанийн үйл ажиллагааны дэлгэрэнгүй танилцуулга;
	1.7.2.(4)	Үйлчилгээ эрхлэх дунд хугацааны буюу 3-5 жилийн стратеги төлөвлөгөө;
	1.7.2.(5)	Үйлчилгээ эрхлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалт, хүний нөөц, шаардлагатай тоног төхөөрөмж, эдийн засгийн тооцоо судалгаа бүхий бизнес төлөвлөгөөг ирүүлэх;
	1.7.2.(6)	Үйлчилгээ эрхлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалт, санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэх чадвартайгаа нотлох 2022 оны жилийн эцсийн баталгаажсан санхүүгийн дэлгэрэнгүй тайлан; шаардлагатай бол хөрөнгө оруулагчийн санхүүгийн эх үүсвэрийн нотлох баримт
	1.7.2.(7)	Стратеги болон бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц бүрдүүлсэн нотлох мэдээлэл;
	1.7.2.(8)	Үйлчилгээ хүргэхэд шаардлагатай студийн болон радио давтамж ашиглахад шаардлагатай нэвтрүүлэгч станцын үзүүлэлт, техник, тоног төхөөрөмжийн танилцуулга;
	1.7.2.(9)	Тоног төхөөрөмжүүдийн стандарт шаардлага хангасан тухай нотолгоо, нийлүүлэгчийн мэдэгдэл
	1.7.2.(10)	Тухайн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний төрлөөс хамаарсан тусгай болон нэмэлт нөхцөл, шаардлагыг хангасан нотолгоонууд; Стратеги

		төлөвлөгөөнд тусгах хөтөлбөр төлөвлөлт, бүтээлийн жагсаалтыг ирүүлэх (Өгөгдлийн хүснэгтийн (1.6.1(5)-д заасан шаардлагын дагуу);
	1.7.2.(11)	Оролцогчийн сонгон шалгаруулалтын эрхийн төлбөр төлсөн баримт; Тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан тохиолдолд тусгай зөвшөөрлийн эрхийн төлбөрийг буцаан авах МАЯГТ-6-д заасан хүсэлтийн хамт ирүүлэх;
	1.7.2.(12)	Радио давтамж ашиглах хүсэлт;
	1.7.2.(13)	Радио давтамжийн тоног төхөөрөмжийн мэдээллийг "МАЯГТ-10"-д заасны дагуу бөглөж ирүүлэх;

5.3. ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН НӨХЦӨЛ ШААРДЛАГА *(Тухайн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага, зохицуулалтын холбогдох баримт бичгийг хавсаргах);*

Дараах линкээр орж “Радиоогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага”-ыг татаж авах боломжтой.

<https://crc.gov.mn/k/36F>

“Радиоогийн хөтөлбөрт тавигдах шаардлага”-ыг дараах линкээр орж татаж авах боломжтой.

<https://crc.gov.mn/k/36E>

“Радиоогоор нэвтрүүлэх зар сурталчилгааны зохицуулалтын журам”-ыг дараах линкээр орж татаж авах боломжтой.

<https://crc.gov.mn/k/36z>

“Хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлэгт ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-ыг дараах линкээр татаж авах боломжтой

<https://www.crc.gov.mn/storage/PDF/20222/008-38-Togtool-Attach-FM-МОЈНА-2022-0831.pdf>

ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦЛҮҮД *(Гэрээний загварыг хавсаргах)*

БАТЛАВ.

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ДАРГА

.....

/Г.ЧИНЗОРИГ/

БАТЛАВ.

#NAME
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

.....

/#DIRECTOR/

АРИЛЖААНЫ РАДИОГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ #NUMBER TOOT ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЭЭ

1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Энэхүү тусгай зөвшөөрлийн гэрээ (цаашид “Гэрээ” гэх)-г Зөвшөөрлийн тухай хууль, Харилцаа холбооны тухай хууль болон Иргэний хуулийг тус тус үндэслэн,

Нэг талаас: 9089314 тоот регистрийн дугаартай Харилцаа холбооны зохицуулах хороо (цаашид “**Зохицуулах хороо**” гэх)

Нөгөө талаас: #register тоот регистрийн дугаартай #name (цаашид “**Тусгай зөвшөөрөл эзэмшигч**” гэх) нар нь Зохицуулах хорооны 2023 оны #decision-ыг үндэслэн байгуулав.

1.2. Гэрээний хугацаа: #syear оны #smoonth сарын #sday-ны өдрөөс #eyear оны #emoonth сарын #eday-ны өдрийн хооронд #period жилийн хугацаатай байна.

1.3. Талуудын албан ёсны мэдээлэл:

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО

#NAME

Хаяг: Метро бизнес төв, А-блок, 5 давхар,
Бага тойруу, 6 дугаар хороо, Сүхбаатарын
гудамж-13, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар
14201

Хаяг: #address

Утас: 304258

Утас: #phone

Факс: 327720

Цахим хуудас: www.crc.gov.mn

Цахим хуудас: #web

Цахим шуудангийн хаяг: info@crc.gov.mn

Цахим шуудангийн хаяг: #email

2. ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ХҮРЭЭ, БАЙРШИЛ

2.1. Радиогийн нэр:

2.2. Үйлчилгээ эрхлэх хүрээ:

2.2.1. Үйлчилгээ эрхлэх нэмэлт хүрээ:

2.3. Үйлчилгээ эрхлэх байршил:

2.3.1. Үйлчилгээ эрхлэх нэмэлт байршил:

2.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэхүү гэрээний 2.3-т заасан үйлчилгээ эрхлэх байршилд үйл ажиллагаагаа тогтмол эрхлэн явуулах үүрэгтэй.

3. ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН НӨХЦӨЛҮҮД

3.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Зөвшөөрлийн тухай, Харилцаа холбооны тухай, Өргөн нэвтрүүлгийн тухай, Зөрчлийн тухай болон холбогдох бусад хууль тогтоомж, энэхүү гэрээ болон гэрээний Хавсралт 1-т заасан дүрэм, журам, зохицуулалтын баримт бичиг, нөхцөл шаардлага, үндэсний стандарт, норм, норматив баримт бичгийг дагаж мөрдөх үүрэгтэй.

3.2. Зохицуулах хороо нь Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага, Радио, телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага, Радио, телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгааны зохицуулалтын журмын хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор радио, телевизийн эфирийн бичлэг хийх, хөтөлбөрт нь хяналт, мониторинг хийх эрхтэй.

3.3. Зохицуулах хороо нь өөрийн баталсан дүрэм, журам, шийдвэр, зохицуулалтын үйлчилгээний хөлс, нөхцөл, шаардлага, стандарт зэрэг тусгай зөвшөөрөл эзэмшигчид хамааралтай, эрх зүйн үр дагавар бүхий баримт бичгийг шинээр баталсан, эсхүл нэмэлт, өөрчлөлт, шинэчлэн найруулга оруулсан бол шийдвэрийг өөрийн цахим хуудас, цахим шуудан эсхүл албан бичгээр мэдээлнэ. Ийнхүү мэдээлснээр тусгай зөвшөөрөл эзэмшигч дагаж мөрдөх үүрэгтэй.

3.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Зохицуулах хорооноос тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага, гэрээний биелэлтэд хяналт тавих зорилгоор хийгдэх төлөвлөгөөт болон

төлөвлөгөөт бус хяналт, шалгалтыг хийлгэх боломжийг олгож, өөрийн байранд саадгүй нэвтрүүлэх, шаардсан баримт бичгийн хуулбарыг авах, тоног төхөөрөмжид хэмжилт, шалгалт хийх нөхцөл бололцоогоор хангана.

3.5.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Зохицуулах хорооноос хийгдсэн хяналт, шалгалтын дүнд илэрсэн аливаа зөрчил дутагдлыг тогтоосон хугацаанд арилгах үүрэгтэй.

3.6.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 15.2-т заасан өөрийн компанийн нэгдлээс бусад этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

3.7.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалахад чиглэсэн радио, телевизийн хөтөлбөрийн дүрмийг мөрдөх, уг дүрмийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Зохицуулах хорооноос хүргүүлсэн зөвлөмж, шаардлагыг биелүүлж ажиллах үүрэгтэй.

3.8.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь үйлчилгээний нөхцөл, тарифыг ил тод, олон нийтэд нээлттэй мэдээлнэ.

3.9.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь харилцаа холбооны зах зээлд шударга өрсөлдөх нөхцөл бүрдүүлэх, өрсөлдөөний эсрэг аливаа үйлдэл гаргахгүй, харилцан ялгаварлахгүйгээр ижил тэгш нөхцөлөөр ил тод, нээлттэй, харилцан ашигтай байх зарчмыг баримтлан ажиллах үүрэгтэй.

3.10.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Радиогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагад өөрөөр заагаагүй бол тухайн хамрах хүрээнд нэг хөтөлбөр бэлтгэн, нэвтрүүлнэ.

4. МЭДЭЭЛЭЛ ИРҮҮЛЭХ, ШАЛГУУЛАХ ЗОХИЦУУЛАЛТ

4.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн албан ёсны хаяг, цахим шуудангийн хаяг, үйл ажиллагаа тогтмол эрхэлж буй байршил, гүйцэтгэх удирдлагын мэдээлэл болон энэхүү гэрээний хавсралт 2-т заасан холбоо барих ажилтны мэдээлэлд өөрчлөлт орсон тохиолдолд тухайн өөрчлөлт орсноос хойш 30 хоногийн дотор Зохицуулах хорооны тусгай зөвшөөрлийн цахим системд бүртгүүлэх үүрэгтэй.

4.2.Радиогийн үйлчилгээний нэрийг өөрчлөх тохиолдолд өөрчлөхөөс 30 хоногийн өмнө Зохицуулах хороонд албан бичгээр мэдэгдэж, холбогдох нэмэлт, өөрчлөлтийг хийлгэнэ.

4.3.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Харилцаа холбооны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.3-т заасны дагуу телевизийн тоног төхөөрөмжийг шинэчлэх, өргөтгөх, түр зогсоох тохиолдолд Зохицуулах хороо, хөтөлбөр дамжуулж байгаа үйлчилгээ эрхлэгчид болон үзэгч, сонсогч, хэрэглэгчид урьдчилан мэдэгдэх үүрэгтэй.

4.4.Энэхүү гэрээний 4.3-т заасан шалтгаанаар үйлчилгээг түр зогсоох бол түр зогсоох хугацаа 3 сараас хэтрэхгүй байна.

4.5.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Зохицуулах хорооны даргын тушаалаар батлагдсан маягтын дагуу тухайн жилийн статистик тайлан мэдээг дараа оны 2 дугаар сарын 20-ны дотор, хагас жилийн статистик тайлан, мэдээг тухайн оны 8 дугаар сарын 1-ний дотор тухайн хугацааны санхүүгийн тайлангийн хуулбарын хамт тус тус Зохицуулах хорооны статистик мэдээллийн /<https://statistic.crc.gov.mn/> цахим системээр дамжуулан ирүүлэх үүрэгтэй.

4.6.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Зохицуулах хорооноос тодорхой үндэслэлтэйгээр бичгээр шаардсаны дагуу энэхүү тусгай зөвшөөрөлд хамаарах баримт бичиг эсхүл мэдээллийг тогтоосон хугацаанд нь үнэн зөв, бүрэн гүйцэд ирүүлнэ.

4.7.Хуульд өөрөөр заагаагүй тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэхүү тусгай зөвшөөрлөөр олгогдсон үйлчилгээнд хамаарах, Зохицуулах хорооноос шаардсан аливаа мэдээллийг нууц гэсэн шалтгаанаар ирүүлэхээс татгалзахгүй бөгөөд тухайн байгууллагын нууцад хамаарах мэдээллийг Зохицуулах хороо өөрийн баталсан нууцын журмын дагуу ашиглана.

4.8.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлийн хугацаа дуусгавар болохоос 30 (гуч)-аас доошгүй хоногийн өмнө тусгай зөвшөөрлийн хугацаа сунгуулах хүсэлтийг Зохицуулах хороонд ирүүлнэ.

5. ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТӨЛБӨРИЙН ЗОХИЦУУЛАЛТ

5.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Зохицуулах хорооноос баталсан "Тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд үзүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ"-нд заасан зохицуулалтын үйлчилгээний хөлсийг тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацааны туршид

жил бүр Голомт банкин дахь Зохицуулах хорооны 1102626829 тоот дансанд нэхэмжлэхийн дагуу төлнө.

5.2.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь зөвшөөрөл шинээр авах, зөвшөөрлийн хугацааг сунгуулах бүртээ Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн холбогдох заалт, 42-р зүйлийн 42.4-т заасны дагуу улсын тэмдэгтийн хураамжийг Зохицуулах хорооны Голомт банкин дахь 1165009467 тоот дансанд төлнө.

5.3.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг тусгай зөвшөөрлийн гэрээ байгуулснаас хойш 10 хоногийн дотор төлөх үүрэгтэй.

5.4.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлийн ээлжит жилийн төлбөрийг жил бүрийн тусгай зөвшөөрөл олгосон тухай шийдвэр гарсан өдрөөс / #smonth сарын #sday-ны өдөр/ нэг сарын өмнө төлнө.

5.5.Тусгай зөвшөөрөл эзэмшигч энэхүү гэрээний 5.3, 5.4-т заасан хугацаанд төлбөрөө төлөөгүй тохиолдолд Харилцаа холбооны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.12.2-т заасан тусгай зөвшөөрлийн гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй үндэслэлээр тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлнэ. Түдгэлзүүлсэн хугацаанд тусгай зөвшөөрөлд заасан үүргийг биелүүлээгүй тохиолдолд Харилцаа холбооны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1-т заасны дагуу тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно.

5.6.Зохицуулах хороо нь энэхүү гэрээний 4.1-т заасан зөвшөөрлийн төлбөрийн хэмжээнд нэмэлт өөрчлөлт орсон тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд мэдэгдэх ба зөвшөөрөл эзэмшигч нь 30 хоногийн дотор гэрээгээ өөрчлөх хүсэлт ирүүлэх үүрэгтэй.

5.7.Радио давтамжийн зурвасыг чөлөөлөх зохицуулалт хийж, тусгай зөвшөөрлийг хугацаанаас нь өмнө хүчингүй болгохоос бусад тохиолдолд тусгай зөвшөөрлийг хугацаанаас нь өмнө хүчингүй болгосон, дуусгавар болгосон тохиолдолд тусгай зөвшөөрлийн тухайн жилийн төлбөрөөс чөлөөлөх үндэслэл болохгүй.

5.8.Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн тохиолдолд түдгэлзүүлсэн хугацаанд зөвшөөрлийн төлбөр тооцогдохгүй бөгөөд зөвшөөрлийг сэргээсэн тохиолдолд түдгэлзүүлсэн хугацааны төлбөрийг нөхөн нэхэмжилнэ. Харин түдгэлзүүлсэн тусгай зөвшөөрлийг хуульд заасан үндэслэлээр хүчингүй болгосон тохиолдолд зөвшөөрлийн төлбөр тооцогдохгүй.

5.9.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хууль, энэхүү гэрээнд заасан хугацаанд төлбөрөө бүрэн барагдуулаагүй, төлбөрийн зөрчилтэй тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн мэдээллийг Монгол банкны зээлийн мэдээллийн санд шилжүүлнэ.

6. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

6.1.Энэхүү тусгай зөвшөөрлийн гэрээг хэрэгжүүлэх явцад аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэхгүй байх эсхүл зөрчсөн тохиолдолд энэхүү гэрээ, мөн Монгол Улсын холбогдох хуулийн дагуу эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Хэрэв нэгдсэн шийдвэрт эс хүрвэл Монгол улсын хууль тогтоомжийн дагуу Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

6.2.Тусгай зөвшөөрлийн эзэмшигчийн тусгай зөвшөөрөлд заасан үйлчилгээтэй холбогдуулан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг Зохицуулах хорооноос баталсан журмын дагуу шийдвэрлэнэ.

7. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛС

7.1.Хууль тогтоомжид заасан гэнэтийн давагдашгүй хүчин зүйлсийн улмаас талуудын аль нэг нь гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол нөгөө талдаа 5 (тав)-н хоногийн дотор бичгээр мэдэгдэх ба энэ тохиолдолд үүрэг гүйцэтгэх хугацаа нь энэхүү нөхцөл байдал үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно.

7.2.Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлс бий болсон нь хуанлийн нэг сараас дээш хугацаагаар үргэлжилбэл талууд асуудлыг харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ. Гэнэтийн давагдашгүй хүчин зүйл гэдэгт гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер усны гамшиг зэрэг байгалийн гамшиг, нийтийг хамарсан үймээн самуун, эмх замбараагүй байдал, ажил хаялт, эрчим хүчний тасалдал, эсэргүүцлийн хөдөлгөөн, гоц халдварт өвчин, дайн, террорист халдлага, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио, цээр, сүлжээний хэвийн ажиллагааны горимоос хэтэрсэн гэнэтийн огцом ачаалал талуудын хүсэл зоригоос үл хамаарах шалтгаануудыг ойлгоно.

7.3.Давагдашгүй хүчин зүйлсийн улмаас талууд гэрээний үүргээ биелүүлээгүй, эсвэл зохих ёсоор биелүүлээгүй бол хариуцлага хүлээхгүй.

8. ХАРИУЦЛАГА

8.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Зөвшөөрлийн тухай хууль, Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, Харилцаа холбооны тухай хууль, Радио долгионы тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль бусад холбогдох хууль, тогтоомж, Зохицуулах хорооноос баталсан дүрэм, журам, норм, норматив баримт бичиг, стандарт, нөхцөл шаардлага болон энэхүү гэрээг удаа дараа зөрчсөн буюу ноцтой зөрчсөн, эсхүл хяналт, шалгалтаас илэрсэн зөрчлийг тогтоосон хугацаанд арилгаагүй тохиолдолд тусгай зөвшөөрлийг хуульд заасны дагуу түдгэлзүүлнэ.

8.2.Тусгай зөвшөөрлийн эрхийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлийг арилгах талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох, биелүүлсэн бол тусгай зөвшөөрлийг сэргээнэ.

8.3.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хууль бусаар ашигласан, засварласан, бусдад шилжүүлсэн, барьцаалсан, тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулахдаа хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь эрх бүхий байгууллагаас нотлогдсон тохиолдолд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно.

9. БУСАД ЗҮЙЛ

9.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ гуравдагч этгээдэд хэсэгчилсэн байдлаар буюу бүрэн хэмжээгээр шилжүүлэх эрхгүй.

9.2.Холбогдох хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, захиргааны акт, зохицуулалтын шийдвэр, үйл ажиллагааны улмаас энэхүү гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Нэмэлт гэрээ нь энэхүү гэрээний салшгүй нэг хэсэг болно.

9.3.Энэхүү гэрээ нь талуудын эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга тэмдэг даран баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилнэ.

9.4.Энэхүү гэрээний 1.3-т заасан тусгай зөвшөөрөл эзэмшигчийн албан ёсны мэдээлэлд заасан хаяг болон цахим шуудангийн хаягаар дамжуулан тусгай зөвшөөрлийн гэрээтэй холбогдон гарах аливаа мэдэгдэл, шаардлага, захидлууд хүргэгдэх бөгөөд тусгай зөвшөөрөл эзэмшигч нь албан ёсны мэдээлэл солигдох бүрт Зохицуулах хороонд мэдэгдэнэ.

9.5.Гэрээг талууд хоёр хувь үйлдэж, тал тус бүр нэг хувийг хадгалах бөгөөд эдгээр хувь бүр хуулийн хувьд ижил хүчин төгөлдөр байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООГ ТӨЛӨӨЛЖ:**

**#NAME
ТӨЛӨӨЛЖ:**

.....
ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА
Э.ЗОЛБАЯР

.....
ХУУЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА
Т.УУГАНБАТ

.....
Зохицуулах хороо болон #name
хооронд байгуулагдсан #сугар оны #number
тоот гэрээний Хавсралт 1

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн дагаж мөрдөх эрхзүйн баримт бичгийн жагсаалт

1. Харилцаа холбооны зохицуулах хорооноос баталсан “Харилцаа холбооны үйлчилгээний тариф тогтоох аргачлал”

2. Харилцаа холбооны зохицуулах хорооноос баталсан “Харилцаа холбооны зохицуулах хороонд ирүүлсэн санал, гомдлыг хүлээн авах, хянах, шийдвэрлэх журам”
3. Харилцаа холбооны зохицуулах хорооноос баталсан “Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ”
4. Харилцаа холбооны зохицуулах хорооноос баталсан “Сүлжээ хооронд харилцан холболт хийх, гэрээний ерөнхий нөхцөл, орлого хуваарилах журам”
5. Харилцаа холбооны зохицуулах хорооноос баталсан “Радиоогийн хөтөлбөрт тавигдах шаардлага”
6. Харилцаа холбооны зохицуулах хорооноос баталсан “Радиоогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”
7. Харилцаа холбооны зохицуулах хорооноос баталсан “Радиоогоор нэвтрүүлэх зар сурталчилгааны зохицуулалтын журам”
8. Харилцаа холбооны зохицуулах хорооноос баталсан “Радио төхөөрөмж ажиллуулах, үйл ажиллагааг нь зогсоох, хориглох журам”
9. MNS 5591-1 Радиоогийн студи. Үндсэн шаардлага.
10. MNS 5591-2 Радиоогийн студи. Тоног төхөөрөмжид тавих үндсэн шаардлага
11. MNS 4909 Давтамжийн модуляцтай (FM) хэт богино долгионы (VHF) нэвтрүүлэгч. Техникийн шаардлага
12. MNS 5476 Давтамжийн модуляцтай радио өргөн нэвтрүүлгийн цахилгаан оронгийн хүчлэгийн хамгаалах харьцаа, зөвшөөрөх хэмжээ

Зохицуулах хороо болон #name
хооронд байгуулагдсан #сугар оны #number
тоот гэрээний Хавсралт 2

ТАЛУУДЫН ХОЛБОГДОХ АЖИЛТНУУДЫН ХОЛБОО БАРИХ ХАЯГ

Харилцаа холбооны зохицуулах хороо					
	Овог нэр	Хариуцах ажил	Албан тушаал	Гар утас	И-мэйл хаяг
1	Д.Уранбилэг	Радиоогийн үйлчилгээний зохицуулалт хэрэгжилтийн асуудал	Радиоогийн үйлчилгээний зохицуулалт хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн	88112368	uranbileg@crc.gov.mn
2	Б.Дэлгэрцэцэг	Тусгай зөвшөөрөл, гэрээтэй холбоотой асуудал	Тусгай зөвшөөрөл хариуцсан мэргэжилтэн	99140090	delgertsetseg@crc.gov.mn
3	Э.Эрдэнэбаяр	Тооцоо нийлэх, данстай холбоотой асуудал	Орлого хариуцсан мэргэжилтэн	88888044	erdenebayar@crc.gov.mn
4	Д.Гантуяа	Тооцоо нийлэх, данстай холбоотой асуудал	Орлого хариуцсан мэргэжилтэн	88097400	gantuya@crc.gov.mn
#name					
1	Хамтын ажиллагаа, гэрээтэй холбоотой асуудал			

2	Тооцоо нийлэх, данстай холбоотой асуудал			
---	-------	---	--	--	--

Зохицуулах хороо болон #name
хооронд байгуулагдсан #сугар оны #number
тоот гэрээний Хавсралт 3

ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ЖИШИГ МАЯГТ

Д/д	Гэрээний заалт	Хэрэгжилт	Тайлбар
1.			
2.			
3.			
4.			
5.			
6.			
7.			
8.			
9.			

(Радиогийн логог гэрээнд хавсаргасан байна.)

БАТЛАВ.
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ
ХОРООНЫ ДАРГА

БАТЛАВ.
#NAME-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

.....

.....

/Г.ЧИНЗОРИГ/

/#DIRECTOR/

РАДИО ДАВТАМЖ АШИГЛАХ, РАДИО ДАВТАМЖИЙН ЗУРВАС АШИГЛАХ Дугаар #number ТООТ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЭЭ

1.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Энэхүү тусгай зөвшөөрлийн гэрээ (цаашид “Гэрээ” гэх)-г Зөвшөөрлийн тухай хууль, Харилцаа холбооны тухай хууль, Радио долгионы тухай хууль болон Иргэний хуулийг тус тус үндэслэн,

Нэг талаас: 9089314 тоот регистрийн дугаартай Харилцаа холбооны зохицуулах хороо (цаашид “**Зохицуулах хороо**” гэх)

Нөгөө талаас: #register регистрийн дугаартай #name /цаашид “**Тусгай зөвшөөрөл эзэмшигч**” гэх/ нар нь Зохицуулах хорооны #сyear оны #decision дугаар тогтоолыг үндэслэн байгуулав.

1.2 Гэрээний хугацаа: #сyear оны #smonth сарын #sday-ны өдрөөс #еyear оны #emonth сарын #eday-ны өдрийн хооронд #period жилийн хугацаатай байна.

1.3 Талуудын албан ёсны мэдээлэл:

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО

#NAME

Хаяг: Метро бизнес төв, А-блок, 5 давхар, Бага тойруу, 6 дугаар хороо, Сүхбаатарын гудамж-13, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201-0033,

Хаяг: #address

Монгол Улс

Утас: 304258, 18001858

Утас: #phone

Факс: 327720

Факс:

Веб хуудас: www.crc.gov.mn

Веб хуудас: #web

Цахим шуудангийн хаяг:
info@crc.gov.mn

Цахим шуудангийн хаяг: #email

1.3 Ашиглах радио давтамж: #f,

1.4 Зурвасын өргөний хэмжээ: #tsaraa

1.5 Тусгай зөвшөөрлийг ашиглах хамрах хүрээ: #location

1.6 Тусгай зөвшөөрлөөр ашиглах тоног төхөөрөмжийн нэр, чадал, тоо ширхэг: #equipment, #telenumber (3.3 заалтын дагуу хавсралт 5-аар жил бүр шинэчлэгдэнэ.)

1.7 Тусгай зөвшөөрлөөр ашиглах технологи: Аналог

1.8 Радио давтамж ашиглах тусгай зөвшөөрлийн төрөл: Хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлэг

1.9 Тусгай зөвшөөрлийг ашиглах үйлчилгээний төрөл: Арилжааны радио

1.10 Үйлчилгээ явуулж буй радиогийн нэр:

2. ЗӨВШӨӨРЛИЙН НӨХЦӨЛҮҮД

2.1. Зохицуулах хороо нь энэхүү зөвшөөрөлд хамаарах чиглэлээр хууль, журам, тогтоол, шийдвэр, зохицуулалтын баримт бичиг, радио давтамжийн ашиглалт үйлчилгээний төлбөр болон улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээ, нөхцөл, шаардлага, стандартад нэмэлт, өөрчлөлт, шинэчилсэн найруулга орох эсвэл шинээр батлагдвал зөвшөөрөл эзэмшигчид (өөрийн вэб хуудсаар эсхүл албан бичгээр) мэдээлнэ. Хэрэв энэ зүйл заалтад дурдагдсан нэмэлт, өөрчлөлт болон шинэчилсэн найруулга нь Зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд нэн чухал ач холбогдолтой, эсхүл төлбөр тооцоонд шууд нөлөөлөхөөр бол Зохицуулах хороо нь энэ талаарх мэдээллийг зөвшөөрөл эзэмшигчид албан бичгээр мэдэгдэнэ.

- 2.2. Зохицуулах хороо нь радио давтамжийн хуваарилалт, зохицуулалтыг хийх бөгөөд хуваарилсан радио давтамжийн зурвасын харилцан нөлөөлөлгүй ажиллах баталгааг хариуцахгүй. Радио давтамж, радио давтамжийн зурвасыг аливаа этгээд зөвшөөрөлгүй ашиглаж байгаа эсэхэд хяналт тавьж, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авна.
- 2.3. Энэхүү тусгай зөвшөөрлөөр олгогдсон радио давтамжийн зурвасыг Дэлхийн радио холбооны дүрэм болон үндэсний радио давтамжийн төлөвлөлт, зохицуулалтын дагуу шинэ төрлийн дэвшилтэт технологи, үйлчилгээ нэвтрүүлэх зорилгоор радио давтамжийн зурвасыг бүрэн болон хэсэгчлэн дахин хуваарилах, зохицуулалт хийх тохиолдолд Зохицуулах хороо нь зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлэх зорилгоор зөвшөөрөл эзэмшигчтэй зөвшилцөж, радио давтамжийг шилжүүлэх, нэмэлт зөвшөөрөл, эрх олгох болон бусад арга замаар асуудлыг шийдвэрлэнэ. Энэхүү дахин хуваарилалт, зохицуулалт нь үндэслэлтэй байна.
- 2.4. Монгол Улсын хилийн бүс дэх радио давтамжийн ашиглалтын зохицуулалтыг олон улсын цахилгаан холбооны байгууллагын зөвлөмж болон хоёр улсын хооронд байгуулсан гэрээгээр зохицуулах ба Зохицуулах хороо нь радио давтамжийн хуваарилалтыг аливаа ялгаваргүйгээр тусгай зөвшөөрөл эзэмшигчид олгоно.
- 2.5. Зохицуулах хороо нь энэхүү гэрээний хавсралт 5-т бүртгэгдээгүй эсвэл тус гэрээний 2.7 заалтын дагуу урьдчилан мэдүүлээгүй радио нэвтрүүлэгч, хамрах хүрээнд үүссэн аливаа гомдол маргааныг хүлээн авч шийдвэрлэхгүй.
- 2.6. Зөвшөөрөл эзэмшигч нь Харилцаа холбооны тухай хууль, Радио долгионы тухай хуульд заасан эрхийг эдэлж, үүрэг хүлээх ба Зохицуулах хорооноос гаргасан энэхүү гэрээний Хавсралт 1-т заасан дүрэм, журам, техникийн нөхцөл, шаардлага, зохицуулалтын баримт бичгийг дагаж мөрдөнө.
- 2.7. Зөвшөөрөл эзэмшигч нь Радио долгионы тухай хуулийн 19.2.4-т заасан техникийн болон ашиглалтын нөхцөлд өөрчлөлт оруулах, сүлжээндээ өргөтгөл хийх, нэмэлт бааз станц суурилуулах тохиолдолд Зохицуулах хороонд урьдчилан албан бичгээр мэдэгдсэний дараа суурилуулалтын ажлыг эхлүүлэх бөгөөд бусад сүлжээний станцуудтай харилцан нөлөөлөл үүсгэхгүй байхаар радио сүлжээг зохион байгуулна.
- 2.8. Зөвшөөрөл эзэмшигч нь энэхүү гэрээний 2.7-д заасныг зөрчсөн, өөрт олгогдоогүй радио давтамж ашигласны улмаас радио давтамжийн харилцан нөлөөлөл үүсгэсэн тохиолдолд уг нөлөөллийг арилгах арга хэмжээг авч ажиллах ба түүнийг арилгахад гарах зардлыг бүрэн хариуцна.
- 2.9. Зөвшөөрөл эзэмшигч нь орон нутагт нэн яаралтай шийдвэрлэх /24 цаг дотор/ шаардлагатай гомдол, маргааныг барагдуулах, цахилгаан соронзон орны хэмжилт хийлгэх тохиолдолд Зохицуулах хороонд хандаж болох бөгөөд энэхүү үйл ажиллагаатай холбоотой инженер, техникийн ажилтныг томилолтоор ажиллуулах хэмжилт, шалгалт хийхтэй холбогдсон зардлыг хариуцна.
- 2.10. Зөвшөөрөл эзэмшигч нь Зохицуулах хороонд радио давтамжийн харилцан нөлөөллийг шийдвэрлүүлэх хүсэлт гаргахаас өмнө өөрийн зүгээс хийгдэх нөлөөлөл арилгах боломжит арга хэмжээг авч ажилласан байна.
- 2.11. Зөвшөөрөл эзэмшигч нь ашиглаж байсан болон энэхүү зөвшөөрлөөр ашиглагдаж буй радио давтамжуудыг зэргэлдээ сувгийн харилцан нөлөөллөөс хамгаалах хамгаалалтын зурвасыг бусад тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй харилцан тохиролцож тогтооно. Тусгай зөвшөөрөл эзэмшигчид тохиролцоонд эс хүрвэл Зохицуулах хороо нь талуудад зөвлөмж өгч ажиллана.
- 2.12. Зөвшөөрөл эзэмшигч нь радио сүлжээний болон хэрэглэгчийн тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа, цахилгаан соронзон зохицоо, радио давтамж ашиглалтын стандарт шаардлага хангасан байдлыг Зохицуулах хороогоор хянуулж тохирлын гэрчилгээ авсан байна.
- 2.13. Зөвшөөрөл эзэмшигч нь антены хаягийг өөрийн ашиглаж буй нэвтрүүлэх антен байгууламжийн нийт тоогоор Зохицуулах хорооноос захиалан авч зааврын дагуу антен тус бүрд бэхэлж байршуулна.
- 2.14. Тусгай зөвшөөрлийг хуульд зааснаас бусад тохиолдолд бусдад худалдах, барьцаалах, бэлэглэх зэргээр шилжүүлэхийг хориглоно.
- 2.15. Энэхүү гэрээний Хавсралт 3-т заасан маягтын дагуу гэрээний хэрэгжилтийг нөхцөл, шаардлага бүрээр гарган, тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаанд жил бүрийн 2 дугаар сарын 20-ны өдрийн дотор Зохицуулах хороонд ирүүлнэ.

- 2.16. Монгол Улсад онц болон дайны байдал зарласан, гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд харилцаа холбооны сүлжээг хууль тогтоомжийн дагуу саадгүй хэрэглүүлнэ.
- 2.17. Өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын үед гамшигтай холбоотой мэдээ, мэдээллийг дараалал харгалзахгүй хүлээн авч дамжуулна.
- 2.18. Гамшиг болон аюулын дохио, сэрэмжлүүлгийг өмчийн хэлбэр үл харгалзан шуурхай, үнэ төлбөргүй дамжуулна.

3. МЭДЭЭЛЭЛ ИРҮҮЛЭХ, ШАЛГУУЛАХ ЗОХИЦУУЛАЛТ

- 3.1. Зөвшөөрөл эзэмшигчийн хаяг, байршил, гүйцэтгэх удирдлага, холбоо барих ажилтны мэдээлэл, хөрөнгө оруулагч, үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч өөрчлөгдсөн бол тухайн өөрчлөлт орсноос хойш 30 хоногийн дотор Зохицуулах хороонд бичгээр мэдэгдэнэ.
- 3.2. Зөвшөөрөл эзэмшигч нь Зохицуулах хорооны даргын тушаалаар батлагдсан маягтын дагуу тухайн жилийн статистик тайлан мэдээллийг дараа оны 2 дугаар сарын 20-ны дотор, хагас жилийн статистик тайлан мэдээллийг тухайн оны 8 дугаар сарын 1-ний дотор тухайн хугацааны санхүүгийн тайлангийн хуулбарын хамт тус тус Зохицуулах хороонд ирүүлнэ.
- 3.3. Зөвшөөрөл эзэмшигч нь энэхүү тусгай зөвшөөрлийн хүрээнд, Зохицуулах хорооноос хуульд заасан үндэслэлийн дагуу бичгээр шаардсан баримт бичиг эсхүл мэдээллийг тогтоосон хугацаанд нь үнэн зөв, бүрэн гүйцэд ирүүлнэ. Талууд нууцын зэрэглэлтэй мэдээллийг харилцан зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд задруулахгүй.
- 3.4. Зөвшөөрөл эзэмшигч нь Зохицуулах хорооноос урьдчилан мэдэгдэж, хуульд заасан үндэслэлээр тусгай зөвшөөрлийн гэрээний нөхцөл, шаардлагын хэрэгжилтийг шалгах зорилгоор томилсон инженер техникийн ажилтныг ажлын байранд чөлөөтэй нэвтрүүлж, тоног төхөөрөмжид хэмжилт шалгалт хийх нөхцөл бололцоогоор хангана.
- 3.5. Зөвшөөрөл эзэмшигч нь олгогдсон үйлчилгээг эрхлэх боломжгүй болж, үйл ажиллагааг бүхэлд нь эсхүл тодорхой хамрах хүрээнд зогсоох тохиолдолд Харилцаа холбооны тухай хуулийн 25.2.3-т заасны дагуу Зохицуулах хороонд урьдчилан мэдэгдэнэ.
- 3.6. Талууд энэхүү гэрээний хэрэгжилтийг хангаж, хамтран ажиллах ажилтнуудыг томилон энэхүү гэрээний Хавсралт 2-оор баталгаажуулна.

4. ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦАА СУНГАХ, НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

- 4.1. Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах бол хүсэлтээ энэхүү тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас 60 буюу түүнээс дээш хоногийн өмнө гаргах ба тусгай зөвшөөрлийн холбогдох журмын дагуу шаардлагатай өргөдөл, тайлан, төлөвлөгөө, баримт материалыг бүрдүүлж ирүүлнэ.
- 4.2. Зохицуулах хороо нь тусгай зөвшөөрлийн хугацаа сунгуулах өргөдлийг хүлээн авснаас хойш ажлын 10 өдрийн дотор тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Радио долгионы хууль болон гэрээний нөхцөл шаардлага хангаж ажилласан эсэхийг хянаж, биелүүлсэн тохиолдолд тусгай зөвшөөрлийн хугацааг дуусахаас нь өмнө сунгаж, нэгдсэн бүртгэлд тэмдэглэнэ.
- 4.3. Зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл эзэмшигчид холбогдох хууль болон гэрээний үүргээ биелүүлээгүй талаарх мэдэгдэл ирүүлээгүй, тусгай зөвшөөрлийн сунгалтыг дуусах хугацаанаас нь өмнө хийгээгүй бол тусгай зөвшөөрөл нь сунгалт хийх хүртэлх хугацаанд хүчинтэй байна.
- 4.4. Тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулах, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох зэрэг зөвшөөрөлтэй холбоотой асуудлыг Зөвшөөрлийн тухай, Харилцаа холбооны тухай, Радио долгионы тухай хуулиар зохицуулах бөгөөд дээрх мэдээллүүд нь Зохицуулах хорооны зөвшөөрлийн мэдээллийн санд хадгалагдана.

5. ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТӨЛБӨРИЙН ЗОХИЦУУЛАЛТ

- 5.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь радио давтамжийн ашиглалтын төлбөрийг Зохицуулах хорооноос баталсан "Радио давтамж ашиглалт, үйлчилгээний төлбөрийн

- хэмжээ"-нд заасан дагуу тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацааны туршид жил бүр Голомт банкин дахь Зохицуулах хорооны 1102626829 тоот дансанд төлнө.
- 5.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь улсын тэмдэгтийн хураамжийг Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 30, 42.4-р зүйл заалтыг үндэслэн тусгай зөвшөөрөл шинээр авах мөн зөвшөөрлийн хугацааг сунгуулах тохиолдолд Голомт банкин дахь Зохицуулах хорооны 1165009467 тоот дансанд төлнө.
 - 5.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг тусгай зөвшөөрлийн гэрээний төслийг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор төлнө.
 - 5.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь радио давтамж ашиглалтын ээлжит жилийн төлбөрийг жил бүрийн тусгай зөвшөөрөл олгосон тухай шийдвэр гарсан өдрөөс 30 хоногийн дотор тус гэрээний 3.3-д заасан мэдээллийг үндэслэн Хавсралт 4-өөр тооцоолсон төлбөрийг төлнө.
 - 5.5. Гэрээнд заасан хугацаанд төлбөрөө төлөөгүй тохиолдолд шийдвэрийг хүчингүй болгох, зөвшөөрлийг түдгэлзүүлэх, цуцлах нөхцөл болно.
 - 5.6. Зохицуулах хороо нь энэ журмын 5.1-т заасан зөвшөөрлийн төлбөрийн хэмжээнд нэмэлт өөрчлөлт орсон тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд мэдэгдэх ба зөвшөөрөл эзэмшигч нь 30 хоногийн дотор гэрээгээ өөрчлөх хүсэлт ирүүлэх ба заасан хугацаа хэтэрсэн тохиолдолд дээрх төлбөрийн хэмжээний өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөнд тооцно.
 - 5.7. Радио давтамжийн зурвасыг чөлөөлөх зохицуулалт хийж, тусгай зөвшөөрлийг хугацаанаас нь өмнө хүчингүй болгохоос бусад тохиолдолд тусгай зөвшөөрлийг хугацаанаас нь өмнө хүчингүй болгосон, дуусгавар болгосон тохиолдолд тусгай зөвшөөрлийн тухайн жилийн төлбөрөөс чөлөөлөх үндэслэл болохгүй.
 - 5.8. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хууль, энэхүү гэрээнд заасан хугацаанд төлбөрөө бүрэн барагдуулаагүй, төлбөрийн зөрчилтэй тохиолдолд Монгол банкны зээлийн мэдээллийн санд шилжүүлнэ.

6. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

- 6.1. Энэхүү тусгай зөвшөөрлийн гэрээг хэрэгжүүлэх явцад аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэхгүй байх эсхүл зөрчсөн тохиолдолд энэхүү гэрээ, мөн Монгол Улсын холбогдох хуулийн дагуу эвийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Хэрэв нэгдсэн шийдвэрт эс хүрвэл хууль тогтоомжийн дагуу Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 6.2. Тусгай зөвшөөрөлд заасан үйлчилгээтэй холбогдуулан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг Зохицуулах хорооноос баталсан журмын дагуу шийдвэрлэнэ.

7. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛС

- 7.1. Хууль тогтоомжид заасан гэнэтийн давагдашгүй хүчин зүйлсийн улмаас талуудын аль нэг нь гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол нөгөө талдаа 5 (тав) хоногийн дотор бичгээр мэдэгдэх ба энэ тохиолдолд үүрэг гүйцэтгэх хугацаа нь энэхүү нөхцөл байдал үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно.
- 7.2. Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлс бий болсон нь хуанлийн нэг сараас дээш хугацаагаар үргэлжилбэл талууд асуудлыг харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ. Гэнэтийн давагдашгүй хүчин зүйл гэдэгт гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер усны гамшиг зэрэг байгалийн гамшиг, нийтийг хамарсан үймээн самуун, эмх замбараагүй байдал, ажил хаялт, эрчим хүчний тасалдал, эсэргүүцлийн хөдөлгөөн, гоц халдварт өвчин, дайн, террорист халдлага, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио, цээр, сүлжээний хэвийн ажиллагааны горимоос хэтэрсэн гэнэтийн огцом ачаалал зэрэг талуудын хүсэл зоригоос үл хамаарах шалтгаануудыг ойлгоно.
- 7.3. Давагдашгүй хүчин зүйлсийн улмаас талууд гэрээний үүргээ биелүүлээгүй, эсвэл зохих ёсоор биелүүлээгүй бол хариуцлага хүлээхгүй.

8. ХАРИУЦЛАГА

- 8.1. Зөвшөөрөл эзэмшигч нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Харилцаа холбооны тухай хууль, Радио долгионы тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль бусад холбогдох хууль, тогтоомж, Зохицуулах хорооноос баталсан дүрэм, журам, норм, норматив баримт бичиг, стандарт, нөхцөл, шаардлага болон энэхүү гэрээг удаа дараа зөрчсөн буюу ноцтой зөрчсөн, эсхүл хяналт, шалгалтаар илэрсэн зөрчлийг тогтоосон хугацаанд арилгаагүй тохиолдолд тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлнэ.
- 8.2. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлийг арилгах талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох, биелүүлсэн бол тусгай зөвшөөрлийг сэргээнэ.
- 8.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлийг хууль бусаар ашигласан, засварласан, бусдад шилжүүлсэн, барьцаалсан, тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулахдаа хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь эрх бүхий байгууллагаас нотлогдсон тохиолдолд тусгай зөвшөөрөл ашиглах эрхийг хүчингүй болгоно.
- 8.4. Харилцаа холбооны тухай хуулийн 15.1.3-д зааснаар тусгай зөвшөөрөл авсан өдрөөс хойш 1 жилийн хугацаанд тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагаа явуулж эхлээгүй, радио нэвтрүүлэх байгууламжаа "Радио төхөөрөмж ажиллуулах, үйл ажиллагааг нь зогсоох, хориглох журам"-ын дагуу зохион байгуулаагүй бол Радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл ашиглах эрхийг хүчингүй болгоно.

9.БУСАД ЗҮЙЛ

- 9.1. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Зохицуулах хорооны даргын шийдвэрт үндэслэх бөгөөд нэмэлт гэрээг бичгээр байгуулсны үндсэн дээр шийдвэрлэнэ. Нэмэлт гэрээ нь энэхүү гэрээний салшгүй нэг хэсэг болно.
- 9.2. Гэрээтэй холбогдон гарах аливаа мэдэгдэл, шаардлага, захидлууд нь бичгэн хэлбэрээр байна. Эдгээрийг биечлэн, цахим хаягаар эсхүл гэрээнд заасан талуудын албан ёсны хаягаар баталгаат шуудангаар хүргүүлснээр хүлээн авсанд тооцох бөгөөд хүргүүлсэн, биечлэн хүлээлцсэн тухай баримтуудыг хадгална.
- 9.3. Энэхүү гэрээ нь талуудын бүрэн эрхт төлөөлөгчид гарын үсэг зурж, тамга тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.
- 9.4. Гэрээг талууд хоёр хувь үйлдэж, тал тус бүр нэг хувийг хадгалах бөгөөд эдгээр хувь бүр хуулийн хувьд ижил хүчин төгөлдөр байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРОО-Г ТӨЛӨӨЛЖ:**

#NAME-Г ТӨЛӨӨЛЖ:

**РАДИО ДАВТАМЖИЙН
ЗОХИЦУУЛАЛТ, ХЯНАЛТЫН
ГАЗРЫН ДАРГА З.АМГАЛАН**

.....
.....
**ХУУЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА
Т.УУГАНБАТ**

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧИЙН ДАГАЖ МӨРДӨХ ЭРХЗҮЙН БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

- 1 Харилцаа холбооны тухай хууль (2001 он)
- 2 Радио долгионы тухай хууль (1999 он)
- 3 Өргөн нэвтрүүлгийн тухай хууль (2019 он)
- 4 Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль (2003 он)
- 5 Зөвшөөрлийн тухай хууль (2022 он)
- 6 ХХМТГ-ын 2016 оны А/59 тушаал “Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт”
- 7 ХХМТГ-ын 2020 оны А/48 тушаал “Радио зурвасыг төлөвлөх, дахин төлөвлөх, хуваарилах, ашиглах журам”
- 8 ЦХХХ-ны сайдын 2022 оны А/37 тушаал “Радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөр тогтоох журам”
- 9 ХХЗХ-ны 2018 оны 24 тогтоол “Тоон радио өргөн нэвтрүүлэгт ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлагыг тогтоож, батлах тухай (DAB+)”
- 10 ХХЗХ-ны 2019 оны 29 тогтоол “Мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжийн загварыг баталгаажуулах журам”
- 11 ХХЗХ-ны 2019 оны 55 тогтоол “Радио төхөөрөмж ажиллуулах, үйл ажиллагааг нь зогсоох, хориглох журам”
- 12 ХХЗХ-ны 2020 оны 71 тогтоол “Радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийн хэмжээ”
- 13 ХХЗХ-ны 2022 оны 38 тогтоол “Хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлэгт ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”
- 14 Бусад эрх зүйн акт”

ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВЬЖ АЖИЛЛАХ АЖИЛТНУУДЫН МЭДЭЭЛЭЛ

Харилцаа холбооны зохицуулах хороо				
Овог нэр	Хариуцах ажил	Албан тушаал	Гар утас	И-мэйл хаяг

1	Б.Дэлгэрцэцэг	Тусгай зөвшөөрөл, гэрээтэй холбоотой асуудал	Тусгай зөвшөөрөл хариуцсан мэргэжилтэн	99140090	delgertsetseg@crc.gov.mn
2	Д.Гантуяа	Тооцоо нийлэх, данстай холбоотой асуудал	Орлого хариуцсан мэргэжилтэн	88097400	gantuya@crc.gov.mn
3	П.Гэрэлтцэцэг	Давтамжийн хуваарилалт, РД төлбөр бодолтын асуудал	Радио давтамжийн хуваарилалт, бүртгэл хариуцсан мэргэжилтэн	91992095	gerelt@crc.gov.mn
4	Б.Мөнхзул	Статистик тайлан мэдээтэй холбоотой асуудал	Зах зээл статистик дүн шинжилгээний мэргэжилтэн	99080502	munkhzul.b@crc.gov.mn
#name					
	Овог нэр	Хариуцах ажил	Албан тушаал	Гар утас	И-мэйл хаяг
1	Хамтын ажиллагаа, гэрээтэй холбоотой асуудал			
2	Тооцоо нийлэх, данстай холбоотой асуудал			
3				

Зохицуулах хороо болон #name хооронд байгуулагдсан #сугаг оны #number тоот гэрээний Хавсралт 3

ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ЖИШИГ МАЯГТ

Д/д	Гэрээний заалт	Хэрэгжилт	Тайлбар
1.			
2.			
3.			
4.			
5.			
6.			
7.			

8.			
9.			

Зохицуулах хороо болон #name
хооронд байгуулагдсан #сугаг оны #number
тоот гэрээний Хавсралт 4

ТӨЛБӨРИЙН ТООЦООЛОЛ

- 1 Радио давтамж ашиглах тусгай зөвшөөрлийн төлбөрийг Цахим хөгжил, Харилцаа холбооны сайдын 2022 оны А/37 тоот тушаалаар батлагдсан “Радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөр тогтоох журам”-ын дагуу дараах томъёоллоор тооцно. Үүнд:

$$P_L = 1.2 \times (F + P + T)$$

F – Радио зурвасын ашиглалтын төлбөр

P – Радио нэвтрүүлэгчийн хүчин чадал/хамрах хүрээний төлбөр

T – Төрөл ангиллын төлбөр

Төлбөрийн хэмжээг ХХЗХ-ны 2020 оны 71 дүгээр тогтоолоор батлагдсан “Радио давтамж ашиглалтын төлбөрийн хэмжээ”-ний дагуу тооцов.

2. Энэхүү хавсралтаар дурдсан төлбөр нь нэг жилийн хугацааг хамарна.
3. Ангилал: Хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлгийн станц
4. Радио давтамж ашиглалтын төлбөрийн тооцоолол:

#havsralt_calc

5. Баталгаажуулалт:

Төлбөрийг тооцоолсон РДЗХГ-ын мэргэжилтэн: #batalan/#сyear.#smonth.#sday/

Төлбөр тооцоотой танилцаж, хүлээн зөвшөөрсөн:

Албан тушаал:

Огноо:Гарын үсэг:

РАДИО ДАВТАМЖ АШИГЛАХ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН МЭДЭЭЛЭЛ

Нэвтрүүлэгчийн мэдээлэл			Нэвтрүүлэгч антены мэдээлэл				Газар зүйн координат		Студийн байршил	Радио давтамжийн мэдээлэл		
Төхөөрөмжийн нэр, загвар	Тоо ширхэг	Гаралтын чадал [Вт]	Антены төрөл	Антену туйлшрал	Тоо ширхэг	Антену өндөр	Антену байршил	Уртраг		Өргөрөг	Төвийн давтамж [МГц]	Зурвасын өргөн [кГц]
	#telenium	#equipment			#telenium	(газрын төвшнөөс дээшх өндөр)	(Хот, аймаг, сум, дүүрэг, хороо, хороолол, байрлал)			(Хот, аймаг, сум, дүүрэг, хороо, хороолол, байрлал)	#rf	#tsaraa

*Нэг мөрөнд нэг байршлын мэдээллийг бичнэ.

Мэдээллийг үнэн зөв гаргасан: / /

Албан тушаал:

Огноо:

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД ОРОЛЦОХ ӨРГӨДЛИЙН МАЯГТ

[огноо]

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНД

Сонгон шалгаруулалтад оролцох тухай

Танай [он, сар, өдөр]-ийн зарласан дугаартай “Арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалтад оролцож, энэхүү сонгон шалгаруулалтын баримт бичиг болон өөрсдийн саналын дагуу..... (хамрах хүрээ) -нд үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй байна.

..... компани нь Сонгон шалгаруулалтын баримт бичигт тусгасан шаардлагуудад нийцүүлэн, оролцогчдод өгөх зааварчилгааны дагуу, саналаа үнэн зөв, бүрэн гүйцэт бэлтгэн битүүмжилсэн дугтуйд хийж үүгээр хүргүүлж байна.

Өргөдөл гаргасан:

Эрх бүхий албан тушаалтны овог, нэр

Албан тушаал

Гарын үсэг, тамга

Хаяг:

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД ОРОЛЦОГЧИЙН БАТАЛГАА

Зөвшөөрлийн тухай хууль, Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд нийцүүлэн Арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл авахад шаардагдах энэхүү сонгон шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлагын дагуу саналаа үнэн зөв бүрдүүлсэн болно.

Сонгон шалгаруулалтын саналыг боловсруулахдаа өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэхтэй холбоотой Монгол Улсын хууль, холбогдох захиргааны хэм хэмжээний актуудыг судалсан, энэхүү сонгон шалгаруулалтын баримт бичиг, түүний бүх хавсралт, тэдгээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг бүрэн хүлээн авч, сайтар танилцсан болно.

Бүрдүүлсэн баримт бичигт худал, ташаа мэдээлэл орсон байвал хуулийн хариуцлагыг бид хүлээх болно.

Өргөдөл гаргасан:

Эрх бүхий албан тушаалтны овог, нэр

Албан тушаал

Гарын үсэг, тамга

Хаяг:

**ТУХАЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХЭД ШААРДАГДАХ
АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ**

№	Ажиллах боловсон хүчний жагсаалт	Мэргэжлийн зэрэг, дэв	Ажлын дадлага туршлага	Тайлбар
А	Инженер техникийн ажилтан (ИТА) 1. 2.			
Б	Мэргэжлийн ажилчид 1. 2.			
В				

Тайлбар: Дээрх хүснэгтэд дараах зүйлүүдийг хавсаргаж, тусгана:

1. Тухайн ашиглалтыг явуулахад шаардлагатай орон тоо;
2. Төгссөн сургууль, цол хэргэм, мэргэжил дээшлүүлсэн байдал;
3. Ажлын дадлага туршлага гэсэн заалтад аль байгууллагад, ямар албан тушаалд, хэдий хугацаанд ажиллаж байсан талаар тодорхой дурдах.

ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

“Радиоогийн студи. 1-р хэсэг: Үндсэн шаардлага” MNS 5591-1:2012 стандартын 2.1-т “**Радиоогийн студи** - Төрөл бүрийн нэвтрүүлгийг бэлтгэх, бичих, боловсруулах, дамжуулах зэрэг радиоогийн үйлдвэрлэл явуулах цогц техник төхөөрөмж бүхий, зайлшгүй шаардагдах нөхцлүүдийг хангасан, гадаад орчны нөлөөллөөс тусгаарлагдсан тусгайлсан объект”-ыг гэж, 3.1-т Радиоогийн студийн байранд тавих шаардлагад **Радиоогийн студи нь дараах 2 хэсгээс бүрдэнэ**: 1. объект байрлах ширээ, микрофоноос бүрдсэн нэвтрүүлэг бэлтгэх, үйлдвэрлэл явуулах үндсэн өрөө; 2. Дууны пулт, бичлэгийн сервер, техникийн гаралтын холбох болон бусад тонг төхөөрөмж, техник хэрэгсэл тэдгээрийг ажиллуулах инженер, техникийн ажилтнууд болон найруулагчид байрлах удирдлага, хяналтын өрөө гэж тус тус заасан байдаг.

Радиоогийн хөтөлбөр бэлтгэж, нэвтрүүлэх, дамжуулахад шаардлагатай сүлжээ, студи, техник тоног төхөөрөмжийг тооцож, төлөвлөсөн байх шаардлагатай болно.

Иймд дор хүснэгтэд үзүүлсэн жагсаалтын дагуу тоног төхөөрөмжийн мэдээллийг бэлтгэхдээ дурдсан стандарт, нөхцөл шаардлагуудыг сайтар судлан үйл ажиллагаандаа уялдуулан дэлгэрэнгүй байдлаар гаргана уу. Холбогдох стандарт, нөхцөл шаардлагыг дараах линкээс үзэж төлөвлөлтөө хийх боломжтой.

Радиоогийн студи. 1-р хэсэг: Үндсэн шаардлага MNS 5591-1:2012

<https://estandard.gov.mn/standard/reader/5449>

Радиоогийн студи. 2-р хэсэг: Тоног төхөөрөмжид тавих ерөнхий шаардлага MNS

5591-2:2016 <https://estandard.gov.mn/standard/reader/5450>

Давтамжийн модуляцтай (FM) хэт богино долгионы (VHF) нэвтрүүлэгч. Техникийн шаардлага MNS 4909:2000 <https://estandard.gov.mn/standard/reader/3471>

“Радиоогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага”-ыг татаж авах боломжтой. <https://crc.gov.mn/k/36F>

№	Ашиглагдах тоног төхөөрөмжийн жагсаалт	Тоо ширхэг (хэмжээ)	Марк, загвар	Техникийн үндсэн үзүүлэлтүүд	Үйлдвэрлэсэн улс (vendor)	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
А	Эфирийн удирдлага хяналтын өрөөнд (master control room) байрлах үндсэн тоног төхөөрөмжийн жагсаалт (дууны мониторууд, микшерт пультауд болон playback серверүүд гэх мэт)						
						
						
п						
Б	Радиоогийн студид ашиглагдах тоног						

	төхөөрөмжийн жагсаалт (микрофон, студийн хяналтын дэлгэц, чанга яригч гэх мэт...)						
						
						
п						
В	Бусад (Командын холбоо, ажлын компьютерууд, card, тог баригч, архивын систем гэх мэтбусад)						
						
						
Д	Гал унтраах систем						
						
						
Е	Студийн тоо, хэмжээ (Ашиглах студийнхээс тооноос хамаарч доош нь цувуулж бичнэ үү.)	Студийн талбай "S" м ²	Студийн өндөр "h" м	Студийн урт, "L", м	Студийн өргөн, "B", м	Нийт хэмжээ	Нийт үнэ

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН САНАЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦААНЫ ХУВААРЬ

Хэрэгжүүлэх ажлууд	Хугацаа /сар, өдөр/				
	сар	сар	сар	сар	сар
1.					
2.					

Тайлбар: Ажлын нэрийг нарийвчилсан задаргаатай гаргана.

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ЭРХИЙН ТӨЛБӨР БУЦААН АВАХ ХҮСЭЛТ

[огноо]

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНД

Эрхийн төлбөр буцаан авах тухай

..... [Сонгон шалгаруулалтад оролцогчийн нэр] нь танай
.....[он, сар, өдөр] -ний өдөр зарласан..... дугаартай “Арилжааны
радиоогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох [Сонгон шалгаруулалтын төслийн
нэр] нээлттэй сонгон шалгаруулалтад оролцож, энэхүү сонгон шалгаруулалтын баримт
бичгийн 4.2.1-д заасны дагуу хамрах хүрээ, тусгай зөвшөөрлийн төрөл тусгай
зөвшөөрлийн **АБ,000,000** (.....) төгрөгийн сонгон шалгаруулалтын **эрхийн төлбөр
төлсөн болно.**

Тус компани нь энэхүү..... тоот сонгон шалгаруулалтад шалгараагүй тохиолдолд энэхүү
баримт бичгийн 4.2.1(1)-д заасны дагуу сонгон шалгаруулалтын эрхийн төлбөрийг
..... компаний..... банкнытоот дансанд буцаан
шилжүүлэхийг хүсье.

Хүсэлт гаргасан:

Эрх бүхий албан тушаалтны овог, нэр

Албан тушаал

Гарын үсэг, тамга

Хаяг:

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ, УДИРДЛАГЫН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮНИЙ
ТАНИЛЦУУЛГА**

(ТУЗ-ийн гишүүд, компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, хяналтын зөвлөлийн гишүүд, Ерөнхий захирал, Гүйцэтгэх захирал, Дэд захирал гм, Ерөнхий нягтлан, Удирдлагын баг, Менежер болон бусад эрх бүхий албан тушаалтан, бусад удирдлагын багийн гишүүн)

д/д	Албан тушаал	Эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр	Регистрийн дугаар	Иргэний харьяалал, Улс	Байнга оршин суугаа газрын хаяг
	1	2	3	4	5
1					
2					
3					
4					
5					
6					
7					
8					
...					

**ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЭЗЭМШЛИЙН ТАЛААРХ
МЭДЭЭЛЭЛ ХҮЛЭЭН АВАХ МАЯГТ**

1.	Өргөдөл гаргасан огноо:	
2.	Хуулийн этгээдийн регистрийн дугаар:	
3.	Хуулийн этгээдийн нэр:	
4.	Үүсэн байгуулагдсан огноо:	
5.	Нийт хувьцаа эзэмшигчийн тоо:	

6. Хувьцаа эзэмшигчийн мэдээлэл:

Хувьцаа эзэмшигчийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр /хуулийн этгээд бол хуулийн этгээдийн нэр*/	Регистрийн дугаар	Харьяалал	Хувьцааны тоо, төрөл (ширхэг)		Эзэмшиж буй хувьцаа нийт үнэ (төгрөг)	Хувьцаанд эзлэх хувь
			Энгийн	Давуу эрхийн		
1	2	3	4	5	6	7
1. Эзэмшигч #1						
2. Эзэмшигч #2						
3. Эзэмшигч #n						
...						

**Хэрэв хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол хуулийн этгээдийн өмчлөлийн бүтцийн зураглалын үргэлжилсэн хэлхээ холбоог хуулийн этгээд тус бүрээр 6.1 хүснэгтийн дагуу мэдүүлнэ. Үргэлжилсэн бүх хэлхээ холбоонд эцсийн өмчлөгч хүн хүртэлх мэдээллийг бүрэн бичнэ./*

6.1 Хуулийн этгээд (1, 2, ...n)-ийн нэр:

Хувьцаа эзэмшигчийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр /хуулийн этгээд бол хуулийн этгээдийн нэр*/	Регистрийн дугаар	Харьяалал	Хувьцааны тоо, төрөл (ширхэг)		Эзэмшиж буй хувьцаа нийт үнэ (төгрөг)	Хувьцаанд эзлэх хувь
			Энгийн	Давуу эрхийн		
1	2	3	4	5	6	7
1. Эзэмшигч #1						
2. Эзэмшигч #2						
3. Эзэмшигч #n						
...						

**Хэрэв хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол хуулийн этгээдийн өмчлөлийн бүтцийн зураглалын үргэлжилсэн хэлхээ холбоог хуулийн этгээд тус бүрээр 6.2 хүснэгтийн дагуу мэдүүлнэ. Үргэлжилсэн бүх хэлхээ холбоонд эцсийн өмчлөгч хүн хүртэлх мэдээллийг бүрэн бичнэ./*

6.2 Хуулийн этгээд (1, 2, ...n)-ийн нэр:

Хувьцаа эзэмшигчийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр /хуулийн этгээд	Регистрийн дугаар	Харьяалал	Хувьцааны тоо, төрөл (ширхэг)		Эзэмшиж буй хувьцаа нийт үнэ (төгрөг)	Хувьцаанд эзлэх хувь
			Энгийн	Давуу эрхийн		

бол хуулийн этгээдийн нэр*/						
1	2	3	4	5	6	7
1. Эзэмшигч #1						
2. Эзэмшигч #2						
3. Эзэмшигч #n						
...						
* /Хэрэв хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол хуулийн этгээдийн өмчлөлийн бүтцийн зураглалын үргэлжилсэн хэлхээ холбоог хуулийн этгээд тус бүрээр 6.2 хүснэгтийн дагуу НЭМЖ мэдүүлнэ. Үргэлжилсэн бүх хэлхээ холбоонд эцсийн өмчлөгч хүн хүртэлх мэдээллийг бүрэн бичнэ./						
7. Эрх бүхий албан тушаалтны жагсаалт: [Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.1: Компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн, гүйцэтгэх захирал, санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтэн, төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга зэрэг компанийн албан ёсны шийдвэрийг гаргахад болон гэрээ, хэлцэл хийхэд шууд болон шууд бусаар оролцдог этгээдийг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно. 84.2: Компани өөрийн онцлогтоо тохируулан эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг компанийн дүрэмдээ заасан байна.]						
Овог, эцэг /эх/-ийн нэр, нэр		Иргэний харьяалал		Албан тушаал		
1.						
2.						
3.						
...						
...						
8. Хуулийн этгээд, түүний хувьцаа эзэмшигч, өмчлөгчийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй бусад хуулийн этгээдэд* эзэмшиж байгаа хувьцаа, хувь хэмжээ: */хэрэв нөхөрлөл бол 8.1 хүснэгтийг мэдүүлнэ./						
Хуулийн этгээдийн нэр, хэлбэр (ХХК, ХК, ...)	Хуулийн этгээдийн регистрийн дугаар, үүсэн байгуулагдсан огноо	Нийт хувьцаа эзэмшигч ийн тоо	Эрхлэх үйл ажиллагаа (дүрэмд зааснаар)	Эзэмшиж байгаа хувьцааны тоо, төрөл (ширхэг)		Хувьцаанд эзлэх хувь
				Энгийн	Давуу эрхийн	
1	2	3	4	5	6	7
1.						
2.						
3.						
...						
...						
8.1 Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй нөхөрлөлд оруулсан эд хөрөнгийн хэмжээ:						
Нөхөрлөлийн нэр, хэлбэр (Бүх гишүүд нь эсвэл зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай, эсвэл хязгаарлагдмал хариуцлагатай)	Хуулийн этгээдийн регистрийн дугаар, үүсэн байгуулагдсан огноо	Нийт гишүүний тоо	Эрхлэх үйл ажиллагаа (дүрэмд зааснаар)	Үүсгэн байгуулах гэрээнд заасан нөхөрлөлийн нийт эд хөрөнгө (төгрөг)	Үүнээс мэдээлэл гаргагчийн оруулсан эд хөрөнгө (төгрөг)	
1	2	3	4	5	6	
1.						
2.						
3.						
...						

...		
9. Хуулийн этгээдийн эзэмшиж буй өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нэр, төрөл, тоо:		
Эзэмшиж байгаа тусгай зөвшөөрлийн төрөл	Олгогдсон огноо	Шийдвэрийн дугаар
1.		
2.		
3.		
...		
10. Хуулийн этгээдийн эрхлэх үйл ажиллагаа (дүрэмд зааснаар):		
11. Нэмэлтээр өгөх тайлбар, мэдээлэл байвал ирүүлэх:		

Өргөдөл гаргаж байгаа эрх бүхий этгээд нь эзэмшлийн талаарх мэдээллийг үнэн зөв, бүрэн гүйцэд гаргаж ирүүлэх үүрэгтэй бөгөөд мэдээллийн үнэн зөвийг хариуцна.

/Хуулийн этгээдийн
тэмдэг/

/Гарын үсэг/

--- оОо ---

**РАДИО ДАВТАМЖ, РАДИО ДАВТАМЖИЙН ЗУРВАС АШИГЛАХ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ХҮСЭХ ӨРГӨДЛИЙН МАЯГТ**

Радио долгионы тухай хуулийн 9 зүйлийн 9.1. "Төрийн эрх бүхий байгууллагаас радио холбоо зохион байгуулах, түүнийг ашиглан үйлчилгээ эрхлэх, нийтийн үйлчилгээний зориулалтаар радио төхөөрөмж ажиллуулахын тулд радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах эрх олгосон баримт бичгийг тусгай зөвшөөрөл гэнэ." Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл авахдаа энэхүү өргөдлийн маягтыг бөглөн ирүүлнэ.

Зөвлөмж:

✓ Та ашиглахаар төлөвлөж байгаа радио тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлтээр уг маягтыг бөглөнө. Хэрэв ашиглах радио тоног төхөөрөмжийн загвар нь 2 болон түүнээс дээш бол энэхүү өргөдлийн маягтыг загвар тус бүрээр бөглөж ирүүлнэ.

✓ Радио нэвтрүүлэгч станцын байршлын мэдээллийг Google Earth програм ашиглан координатыг "decimal degrees" /DDD.DDDDD/ форматаар үнэн зөв бөглөнө.

Асуумж:	Бөглөх хэсэг:		
Өргөдөл гаргасан огноо:	Он сар өдөр		
Зөвшөөрөл хүсэгчийн нэр:			
Регистрийн дугаар:			
Албан хүсэлт	Нийтийн хэрэглээнд /зориулалтаар/ үйл ажиллагаа эрхлэх хүсэлтэй байгаа тул зохих журмын дагуу радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгоно уу.		
	(Албан бичгээр хавсаргаж болно.)		
	Радио станц ашиглах байршлыг бичнэ үү. Хот/аймаг Дүүрэг/ сум		
Зөвшөөрөл хүсэж буй хугацаа	<input type="checkbox"/> 5 жил (Радио долгионы тухай хуулийн 12.1-д заасан хугацаа)		
1. Зөвшөөрөл хүсэгчийн мэдээлэл:			
Зөвшөөрөл хүсэгчийн албан ёсны хаяг, байршил	Аймаг / Хот		
	Сум / Дүүрэг		
	Баг / хороо		
	Гудамж / Өргөн чөлөө		
	Байр, тоот		
	Шуудангийн нэгдсэн код (Зип код)		
Утас			
Цахим хуудас			
Цахим шуудан			
Хариуцсан ажилтан	Овог, Нэр	Утас	Цахим шуудан

Захирал			
Төлбөр тооцооны ажилтан			
Инженер техникийн ажилтан			
2. Радио тоног төхөөрөмжийн мэдээлэл:			
2.1. Та ашиглах радио тоног төхөөрөмжийн ашиглалтын зориулалтаас хамаарч дараах харгалзах хавсралтыг бөглөж хавсаргана уу.			
<ul style="list-style-type: none"> • Радио өргөн нэвтрүүлгийн үйлчилгээнд радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах станц 			<input type="checkbox"/> Хавсралт 5
2.2. Байгууллагын бүтэц, удирдлага, үйл ажиллагааны танилцуулга болон радио давтамж ашиглах тусгай зөвшөөрлийн хэрэгцээ шаардлага, төлөвлөж буй үйл ажиллагааны танилцуулга	<input type="checkbox"/> Тийм	Хуудасны тоо:	
2.3. Ашиглах тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлт	<input type="checkbox"/> Тийм	Хуудасны тоо:	
2.4. Тоног төхөөрөмжийн баталгаажуулалтын талаарх мэдээлэл <input type="checkbox"/> Тохирлын гэрчилгээ / Certificate of conformity <input type="checkbox"/> Нийлүүлэгчийн мэдэгдэл / Suppliers Declaration of conformity / product certificate	<input type="checkbox"/> Тийм	Хуудасны тоо:	
2.5. Радио төхөөрөмжийн байгуулалтын зураглал, технологи, төхөөрөмжийн ажиллагааны зарчим, блок схемийг хавсаргах	<input type="checkbox"/> Тийм	Хуудасны тоо:	
2.6. Радио нэвтрүүлэгчийн газар зүйн байршил, хамрах хүрээний зураглал	<input type="checkbox"/> Тийм	Хуудасны тоо:	
2.7. Үйл ажиллагаа эрхлэх судалгаа хийсэн байдал <input type="checkbox"/> Тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхлэх бизнес төлөвлөгөө <input type="checkbox"/> Тухайн төлөвлөгөөг хэрэгжүүлэх хугацааны хуваарь	<input type="checkbox"/> Тийм	Хуудасны тоо:	
3. Нийт ашиглахыг хүссэн радио давтамж, давтамжийн зурвасын мэдээлэл:			
Нэвтрүүлэх радио давтамж (Tx):			
Хүлээн авах радио давтамж (Rx):			
Нийт ашиглахыг хүссэн радио давтамжийн зурвас, зурвасын өргөний хэмжээ:			
4. Бусад нэмэлт мэдээлэл:			

<p>Дээр дурдагдаагүй үйл ажиллагаа эрхлэх болон тоног төхөөрөмжтэй холбоотой энэхүү өргөдлийн маягтад дурдагдаагүй нэмэлт мэдээллийг энэ хэсэгт бичнэ үү.</p>	<input type="checkbox"/> эсвэл хавсаргах
---	--

5. Өргөдөл гаргагчийн баталгаа:

Зөвшөөрлийн тухай хууль, Харилцаа холбооны тухай хууль, Радио долгионы тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Харилцаа холбооны зохицуулах хорооноос баталсан тухайн радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл шаардлагад нийцүүлэн энэхүү зөвшөөрөл авахад шаардагдах баримт бичгийг үнэн зөв бүрдүүлж, хүргүүлэв.

Энэхүү маягтын дагуу өгсөн мэдээлэл, тодорхойлолт, материалууд худал, буруу эсхүл бүрэн бус тохиолдолд хуульд заасан хариуцлагыг хүлээх болно.

Харилцаа холбооны салбарын холбогдох журам, стандарт, норм, норматив, тухайн радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл шаардлагыг хангаж ажиллахаа баталгаажуулав.

Энэхүү зөвшөөрлийн хүсэлтэд ашигласан Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд заасан хүний хувийн мэдээлэлд хамаарах эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар, боловсрол, нийгмийн даатгалын мэдээллийг мэдээллийн эзнээс хуульд заасан хэлбэрээр гаргуулан авч, хүргүүлэв.

Өргөдөл гаргасан:

Овог, нэр	Албан тушаал	Гарын үсэг	Огноо

Тамга:

ХАВСРАЛТ 5: РАДИО ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД РАДИО ДАВТАМЖ, РАДИО ДАВТАМЖИЙН ЗУРВАС АШИГЛАХ СТАНЦ

Санамж:

- Хэрэв тоног төхөөрөмжийн загвар нь 2 болон түүнээс дээш бол “нэвтрүүлэгчийн үзүүлэлт” хэсгийг загвар тус бүрээр бөглөнө.
- “Нэвтрүүлэгчийн байршил” хэсэгт станцын байршил бүрийг засаг захиргааны нэгж болон координатаар бичнэ.
- Хэрэв станц нь 5 болон түүнээс дээш байршилд байх бол “excel” файл хэлбэрээр давхар ирүүлнэ.

1. НЭВТРҮҮЛЭГЧИЙН МЭДЭЭЛЭЛ / INFORMATION OF TRANSMITTER

1.1. Нэвтрүүлэгчийн байршил / Location of transmitter

Хот, дүүрэг, сум, хамрах хүрээ, ажиллах газрын нэр / City, province, area of coverage

Уртраг / Longitude / E	Өргөрөг / Latitude / N

1.2. Нэвтрүүлэгчийн үзүүлэлт / Radio transmitter details

Станцын ангилал / Class of station	Төхөөрөмж үйлдвэрлэгч, загвар / Manufacturer, model	Станцын төрөл / Station type
<input type="checkbox"/> FM радио <input type="checkbox"/> AM радио <input type="checkbox"/> DAB+ радио <input type="checkbox"/> Бусад /other/:		<input type="checkbox"/> Суурин / Fixed <input type="checkbox"/> Бусад / Other

Радиоогийн нэр / <i>Call Sign</i>	Ажиллах боломжтой давтамжийн зурвас (МГц) / <i>Available frequency band (MHz)</i>	Зурвасын өргөн (МГц) / <i>Frequency bandwidth (MHz)</i>	
Станцын тоо / <i>Quantity</i>	Гаралтын чадал (Вт) / <i>Transmitter power (W)</i>	Хамрах хүрээ / <i>Service area</i>	
Идэвхтэй цацаргалтын чадал (Вт) / <i>Power_e r p (W)</i>	Нэвтрүүлэх технологи / <i>Transmitting technology</i>	Хангах стандарт / <i>Compatible Standart</i>	
	<input type="checkbox"/> Аналоги <input type="checkbox"/> Тоон		
1.3. Антены үзүүлэлт / <i>Antenna details</i>			
Антенy үйлдвэрлэгч, Загвар / <i>Manufacturer, Model</i>	Тоо ширхэг / <i>Quantity</i>	Антенy төрөл / <i>Antenna type</i>	
Өсгөлтийн коэффициент (дБ) / <i>Gain(dB)</i>	Антенy ажиллах давтамж (МГц) / <i>Antenna frequency range (MHz)</i>		
Туйлшрал / <i>Polarization</i>	Антенy өндөр (м) / <i>Antenna height (m)</i>		
Босоо өнцөг (Градус) / <i>Elevation V (Degree)</i>	Хэвтээ өнцөг (Градус) / <i>Azimuth E (Degree)</i>		
2. НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ: / <i>ADDITIONAL INFORMATION</i>			
3. ТӨХӨӨРӨМЖ ХАРИУЦАХ АЖИЛТНЫ МЭДЭЭЛЭЛ: / <i>RESPONSIBLE PERSONNEL LIST</i>			
Овог, Нэр / <i>Name</i>	Албан тушаал / <i>Position</i>	Утас / <i>Phone</i>	Цахим шуудан / <i>E-mail</i>